

**ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2019 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1	ЗГ-ын 2018.12.26-ны өдрийн 400 дугаар тогтоол.	Хөтөлбөрийн зорилго: ХХАА-н үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчилж хөгжүүлэх, төрөлжүүлэн эрчимжүүлэх, төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, тэдгээрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахад энэ хөтөлбөрийн зорилго оршино.			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв, гадаадын төсөл (зээл), хувийн хэвшлийн хөрөнгө оруулалат, буцалтгүй тусламж			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ. I үе шат: 2019-2020 он. II үе шат: 2021-2023 он. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: МЭЕГ, яамны харьяа байгууллага, аймаг, сумын ЗДТГ.			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх, Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, Гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамжийг сайжруулах, Эрчимжсэн мал аж ахуйн техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашгийг нь нэмэгдүүлэх, Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах, Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачлага хөрөнгө оруулалыг урт хугацааны хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих, Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг сайжруулах, чадавхжуулах.			
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)			
Үүнд		Төсөв (2019 он) сая төг	Гүйцэтгэл сая төг	Хувь	
Улсын төсөв		ЖДҮХС	10528.0	49.54	
Орон нутаг		-	4920.0	23.15	
Төсөл хөтөлбөр		-	300.0	1.41	
Хувийн		-	5500.0	25.88	
	Нийт	21248.0	100		
6	Хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.			
	1-р зорилтын хүрээнд: Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 389 малчдын бүлэг 3890 га бэлчээрийг бэлчээр ашиглах гэрээ байгуулан 15 жилийн хугацаатай бэлчээрийг гэрээгээр ашиглаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолоор тариалангийн бүс нутгийг тогтоож Засгийн газраас тогтоосон 7 аймгийн 60 сум, 113 багийн тариалангийн бүс нутагт зөвхөн эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бөгөөд тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүд талбайн тодорхой хэсэгтээ тэжээл тариалж, малчдаа дэмжих зохицуулалт бий болгосон. Дархан-Уул аймгийн Орхон, Хонгор сумыг тариалангийн, Дорноговь аймгийн Өргөн сумын Зээгийн Хөтөлийн 40 га газрыг газар тариалан, мал маллагааны бүс нутгаар, Төв аймгийн Аргалант, Архуст, Батсүмбэр, Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэсант сумын 1,2,3,4 дүгээр багуудыг тус тус газар тариалангийн бүс нутгаар тогтоосон. Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/451 дүгээр захирамжаар “Нийслэлийн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг баталсан. Энэ хөтөлбөрийн 2.2-т Нийслэлд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтооно гэж заасны дагуу 2019 онд Нийслэл орчимд эрчимжсэн мал аж ахуйг цогц байдлаар хөгжүүлэх чиглэлээр суурьшлын 3 бүсийг шинээр бий				

<p>болгосон. Үүний хүрээнд Төв аймагт сүүний чиглэлийн үхрийн 5, махны чиглэлийн үхрийн 2, Сэлэнгэ аймагт махны чиглэлийн үхрийн 10, Улаанбаатар хотод махны чиглэлийн хонины 2, сүүний чиглэлийн үхрийн 11 аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, 2020 онд энэ үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үр дүнд нь эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж хөгжүүлэх, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээ сайжирна.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, сүү, сүүн бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортыг дэмжих зорилтуудыг үндэслэн ХХААХҮ-ийн сайдын А-313 тоот тушаалын дагуу сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох хууль, эрх зүйн орчныг бий болгох, импортлогч улсын холбогдох эрх бүхий байгууллагын хийх эрсдэлийн хянан магадалгааг зохион байгуулав. Үүний хүрээнд БНХАУ-ын 4 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг хүлээн авч, экспортын эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах ажлыг 6 хоног зохион байгуулсан. Хөтөлбөрийн дагуу МЭЕГ, МХЕГ, УМЭАЦТЛ болон сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Витафит милк”, “Милко”, “Маку”, “Айс марк” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, “Баян симментал”, “Хишигтэн нүүдэлчин” фермийн үйл ажиллагаатай тус тус танилцаж, манай улсаас сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг дүгнэж хариу ирүүлэхээр болсон. Үүний үр дүнд импортын хуурай сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ буурч, дотоодын үйлдвэрийн хүчин чадал сайжрах, ажлын байр, экспортын бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэнэ.</p>
<p>3-р зорилтын хүрээнд: Гойд ашиг шимт үржлийн мал шалгаруулах, өндөр ашиг шимтэй мал, амьтныг олон нийтэд сурталчлах, малчид, үйлдвэрлэгчдийн хөдөлмөр бүтээлийг үнэлэх, харилцан туршлага солилцох зорилгоор “Шилмэл мал-2019” үзэсгэлэн худалдааг Төв аймгийн Зуунмод хотноо 9 сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд 19 аймаг, нийслэлийн 45 сум 6 дүүргийн 506 толгой мал, 5 толгой молтогчин туулай, бөднө, цацагт хяруул зэрэг 14 толгой шувуу нийт 525 толгой мал, амьтан шалгаруулалтад бүртгүүлэв. Эдгээрээс 12 номинацад 44 толгой мал, амьтныг улсын шилмэл мал, амьтнаар шалгаруулж шагнаж урамшуулав. Мөн “Шилдэг оролцогч иргэн”-ээр 2, “Шилдэг оролцогч аймаг”-аар 2, “Шилдэг оролцогч аж ахуйн нэгж”-ээр 2, “Шилдэг түнш байгууллага”-аар 2 аж ахуйн нэгжийг тус тус шалгаруулж, урамшуулав. Үржлийн малын үнэ хаялцуулах дуудлага худалдаанд нийт 45 толгой мал оролцуулан 3 толгой малыг худалдаалан 10.0 сая төгрөгийн борлуулалт хийлээ. Цэвэр үүлдрийн үхрийн аж ахуй эрхэлдэг “Нүүдэлчин” ХХК нь 2019 оны эхний хагаст 3 тэрбум төгрөгийн аж ахуйн хөрөнгө оруулалтаар тус бүр 20 үнээтэй 2 кластер ферм байгуулсан. Дархан-Уул аймаг орон нутгийн төсөвт цэвэр үүлдрийн махны үхрийн аж ахуйн суурьшлын бүс байгуулахад шаардлагатай 500 сая төгрөгийг тусгаж Булган аймгаас Сэлэнгэ үүлдрийн 100 толгой хээлтэгч худалдан авч, үржүүлж байна. 2018 онд цэвэр, эрлийз сүүний үхэр 75.1 мянган толгой байсны 25 хувь буюу 18.8 мянган толгой цэвэр үүлдрийн сүүний үхэр байсан. 2019 онд сүүний үхэр 100.9 мянган толгой болж өссөн. Үүнээс цэвэр үүлдрийн үхэр 24.3 мянга болж, өмнөх оноос 5.5 мянган толгой буюу 29.3 хувиар өссөн байгаа нь зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн байна. Монгол Улс, Беларусь улсын ЗГ хоорондын хөнгөлөлттэй урт хугацааны зээлээр 2019 онд сүүний чиглэлийн хар тарлан үүлдрийн 1300 толгой хээлтэй гунжийг импортлон газар тариалан, тэжээлийн аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг түшиглэн тус бүр 300 үнээний хэд хэдэн цогцолбор ферм байгуулах тухай гэрээ, хэлэлцээр хийж, санамж бичигт гарын үсэг зурсан. Азийн Хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хөрөнгөөр Швейцарь улсаас сүүний чиглэлийн “Голштейн” (Хар тарлан), “Симменталь”, мах-сүүний чиглэлийн “Brown Swiss”, “Original Brounvieh”, “Ангус” Улаан, махны чиглэлийн “Лиммузин” үүлдрийн өндөр ашиг шимт хүйс жолоодсон 1200 тун охин үр, 12.8 мянган тун гүн хөлдөөсөн үр, нийт 14.0 мянган тун үрийг 620.2 сая төгрөгийн /234.5 мянган ам доллар/ хөрөнгөөр худалдан авч Малын удмын сангийн үндэсний төвд хүлээлгэж өгч, нийслэл болон томоохон хот суурингийн ойролцоох цэвэр үүлдрийн үхэрт зохиомол хээлтүүлэг хийж эхлээд байна. ЖДҮХС-ийн захирлын 2019 оны А/77, А/81, А/117 дугаар тушаалуудаар Нийслэл хот болон томоохон хот суурингийн ойролцоо сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 18 аймгийн 45 иргэн, аж ахуйн нэгжид 2.8 тэрбум, махны үхрийн аж ахуй эрхлэгч 14 аймгийн 34 иргэн, аж ахуйн нэгжид 5.9 тэрбум төгрөг, нийт 79 иргэн, аж ахуйд 8.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 жилийн хугацаатай бага хүүтэй олгосон. Эдгээр арга хэмжээний үр дүнд сүү, махан бүтээгдэхүүний импортын хэмжээг буурч, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ өсөх хандлага ажиглагдаж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар 731 өрх, аж ахуйн нэгжид 21,3 мянган гахай, 1526 өрх, аж ахуйн нэгжид 956,0 мянган өндөглөгч тахиа байгаа нь тахианы аж ахуй тоо 2018 оны түвшингээс 350 өрх, аж ахуйн нэгж буюу 30.0 хувиар өсч, харин гахайн тоо өсөөгүй байна. Энэ нь 2019 онд гахайн гоц халдварт мялзан өвчин гарснаас 2 аж ахуйн нэгжийн 3200 гаруй гахайг зориудын устгалд оруулсан болон аж ахуйн нэгжүүд хувиараа гахайг нядалгаанд оруулсантай холбоотой байна. Улсын төсвөөс гахай, шувууны аж ахуйд дэмжлэг үзүүлэхгүй байгаагаас орон нутаг дахь жижиг аж ахуйн тоо цөөрч байна. 2019 оны жилийн эцсийн өндөглөгч тахианы тоо толгойг 2018 онтой харьцуулахад 300 гаруй мянган толгой буюу 30 гаруй хувиар нэмэгдэж байгаа нь өндөгний импортыг 13 хувиар бууруулах бүрэн боломжтой гэж үзсэн. Харин 2018 онд 135.8 сая ширхэг өндөг, 2019 онд 150 сая ширхэг өндөг импортолж өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 14.2 сая ширхэг өндөг буюу 9.5%-иар өссөн байна.</p>

<p>Улсын хэмжээнд 2019 онд 300 сая ширхэг өндөг хэрэглэсэн ба үүний 50 хувь буюу 150 сая ширхгийг ОХУ-аас импортоор, 150 сая ширхэг өндгийг дотоодын шувууны аж ахуй эрхлэгчид үйлдвэрлэсэн байна. Өндөгний хэрэглээ жил бүр өсөж байгаа бөгөөд импортын хэмжээ, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ хамтдаа өсөж байгаа нь төв суурин газрын хүн амын өсөлт, уг бүтээгдэхүүний хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбоотой байна. Шувууны аж ахуй эрхлэх чиглэлээр ЖДҮХС-аас Улаанбаатар хотод 2 төсөл, орон нутагт 5 төслийг сонгон шалгаруулж нийт 1.3 тэрбум төгрөгийн урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг олгосон. Харин "Түмэн шувуут" ХК аж ахуйн хөрөнгөөр бонд гарган үйл ажиллагаагаа өргөтгөн 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 120.0 мянган шувууны 3 байрыг шинээр ашиглалтад оруулж Био иодтой өндөг, Омега-3 агууламж өндөртэй өндөг зэрэг "бренд бүтээгдэхүүн"-ийг үйлдвэрлэж эхэлсэн байна. Жилдээ 150-180 тонн зөгийн бал хураан авах хүчин чадалтай анхны МонАпикластерыг байгууллаа. Үүний үр дүнд зөгийн аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, зөгийчдийн мэдлэгийг дээшлүүлж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжих, өөрхийн үйлдвэрлэлээс арилжааны шинжтэй бизнесийн төрлийг олшруулах, зөгийн бүтээгдэхүүний борлуулалт, орлогыг нэмэгдүүлнэ.</p>
<p>4-р зорилтын хүрээнд Хадлан бэлтгэлд зориулж ОХУ-аас техникийн зээлийн хүрээнд хаман боогч 40 ширхэг, бага оврын трактор, хадуур тармуур тус бүр 20 ширхгийг 30 хувийн урьдчилгаатай, 5 жилийн хугацаатай лизингээр олгох ажлыг, Хөгжлийн банкны "Ди Би Эм Лизинг" ХХК-тай хамтран олгов. Мөн өвс хаман боогч 29 ширхэг, өвс плёнкоор боогч 5 ширхэг, хадуур, тармуур нийт 26 ширхэг, тэжээл хураагч чиргүүлийн комбайн 8 ширхгийг 10-30 хувийн урьдчилгаатай жилийн 4.0-5.6 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай аж ахуйн нэгжүүдэд лизингээр олгож дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэлт 3%-иар, техник, технологийн шинэчлэлийг үе шаттай нэмэгдүүлж, бүтээмж үр ашгийг сайжруулав. Үүний үр дүнд технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж үр ашиг нь 2019 оны байдлаар 3 хувиар нэмэгдсэн тооцоо гарсан.</p>
<p>5-р зорилтын хүрээнд Төв суурин газрын хүн амыг үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнээр хангах ажлыг нийслэлийн хэмжээнд 140 орчим, Дархан-Уул аймагт 100 гаруй худалдааны цэгээр дамжуулан тус тус худалдах ажлыг зохион байгуулсан. Нийслэлийн хүн амын махны хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээр мах бэлтгэсэн дотоодын үйлдвэрт хүүгийн хөнгөлөлт үзүүлж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах арга хэмжээг зохион байгуулсан. Арилжааны банкны шалгуурт тэнцсэн "Баатрууд Тэнгэр", "Дархан мийт фүүдс", "Сүхбаатар мах маркет" ХХК 4.0 мянган тн мах бэлтгэснийг нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс нийлүүлж, нийслэлийн 8 дүүргийн хүнсний 137 дэлгүүрээр дамжуулан үхрийн ястай мах 7200 төг/кг, хонины ястай мах 6000 төг/кг, ямааны ястай мах 5500 төг/кг үнээр худалдаалсан нь зах зээл дэх жижиглэнгийн үнээс 16-45 хувиар хямд байсан. Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сэрүүний улиралд 35%, дулааны улиралд 65%-ийг бүрдүүлж, нийлүүлэлтийн 84.3 хувийг бүрдүүлж байгаа боловч зөвхөн улирлын чанартай тул өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын сүүний хэрэгцээг бүрэн хангахгүй байна. Иймд аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн 85%-д импортын хуурай сүү сэргээж боловсруулсан бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлд байна. Төвлөрсөн хот суурин газрын сүүний хэрэгцээг тогтвортой хангах, улирлын хамаарал, импортыг бууруулах зорилгоор гарал үүсэл нь баталгаажсан, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан сүүг үйлдвэр, цехэд нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн механизмыг бий болгох, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх, сүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор сүүний урамшууллын журмын төслийг боловсруулж байна.</p>
<p>6-р зорилтын хүрээнд ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 04 дүгээр зөвлөмжөөр ЖДҮХС-гаас олгох нийт зээлийн 25-аас доошгүй хувийг "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зээл олгохоор тусгасан. ЖДҮХС-ийн захирлын 2019 оны А/77, А/81, А/117 дугаар тушаалуудаар сүүний чиглэлийн болон махны чиглэлийн үхэр, сарлаг, тэмээ, хонь, тахиа, гахай, зөгий, загасны аж ахуйн 101 иргэн, аж ахуйд нийт 10 тэрбум 528 сая 490.7 мянган төгрөгийн зээлийг 5 жилийн хугацаатай олгосон. Үр дүн нь малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангасан.</p>
<p>7-р зорилтын хүрээнд Эрчимжсэн мал аж ахуйн төвийн бүсийн зөвлөгөөнийг Дархан-Уул аймагт 4 сард, зүүн бүсийн зөвлөгөөнийг Дорнод аймагт 5 сард зохион байгуулж, нийт 240 гаруй, нарийн нарийвтар ноост хонь үржүүлэгчдийн болон сарлаг үржүүлэгчдийн улсын зөвлөгөөнд тус тус 200 гаруй, мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөө хөрөнгө оруулагчдын форумыг Улаанбаатар хотод 10 сард, сүү-сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн чуулганыг 12 сард тус тус зохион байгуулж 21 аймгийн нийт 1400 орчим эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл оролцов. Хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд малчдыг мэдлэгжүүлэх болон залуу халааг бэлтгэхэд чиглэгдсэн мал маллах арга ажиллагааны сургалт, туршлага</p>

	солилцох уулзалтад 2260 өрхийн 3387 малчин иргэн хамрагдаж 361.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Дундговь аймгийн 15 сумын 460, Сүхбаатар аймгийн 5 сумын 110 малчинд бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн нэгжид ялган төвлөрүүлэх, олон наст тэжээлийн ургамал тариалах сургалтыг 120 малчин, фермер хамруулан Улаанбаатар хотод, ЖДҮ хөнгөлөлтэй зээлд хэрхэн хамрагдах талаар сургалт семинарт 60 фермерт, Онцгой байдлын газартай хамтарч Дундговь аймагт үлийн цагаан оготногой бүх нийтийг хамруулан тэмцэх сургалтад албан хаагч, иргэд, малчдыг оролцуулан, Сэлэнгэ, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймагт малчдын зөвлөгөөн тус тус зохион байгуулсан.									
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>1. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн үнэлгээ 2019 оны байдлаар 78.6 хувь, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 71 арга хэмжээний биелэлтийн үнэлгээ дунджаар 78.8 хувьтай байна. Үүнээс үр дүнтэй 32 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 28 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 11 арга хэмжээ байна.</p> <p>2. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлснээр эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх замаар олон улсын жишиг, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулах чухал ач холбогдолтой тул удаашралттай байгаа арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх.</p> <p>3. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, гадаадаас өндөр ашиг шимтэй мал, амьтан, үржүүлгийн бүтээгдэхүүн импортлох, судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг зайлшгүй шаардлагатай санхүүжилтийг төсөвт суулгах.</p> <p>4. Үр дүнгийн биелэлтийг бичихдээ нэг арга хэмжээний үзүүлэлтийг хэд хэдэн арга хэмжээнд давхар тусгаж, өмнөх он, улирлын тайлан мэдээтэй харьцуулан гарсан өөрчлөлтийг дүгнэхгүй, санхүүг тусгахгүй байна.</p> <p>Сайн тал нь: Аймгууд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс орон нутгийн төсвөөс тодорхой хэмжээний санхүүжилт гаргаж байна. Гадаадын төсөл, хувийн хэвшил сайн хамтран ажиллаж хийж байна. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, ган зудын давтамж, газрын доройтол, бэлчээрийн хомсдол, даац хэтрэлт, малын тооны хэт өсөлт зэрэг нь нөөцийн хязгаарлагдмал байдлыг үүсгэж, МАА үйлдвэрлэлийг явуулах арга барилыг өөрчлөн, боловсронгуй болгох эрэлт хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж иргэдийн дунд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх үүсгэл санаачилга нэмэгдэж байна.</p>								
8	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ				Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчид хамтын ажиллагаа сайн байна.					
9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Үр дүн	1	2	3	4	5	6	7
		78.84 %	Биелэлт, %	96.25	65.71	66.42	77.5	75.0	80.0	91.0
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)				Нэгдсэн үнэлгээ ... %					

ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг арга хэмжээгээр задлан биелэлтийг тооцож үнэлсэн.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаар товч тайлбар

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2019 онд хийсэн ажлын биелэлт, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох статистик мэдээ, мэдээллийг ашиглан, нэмэлт тайлбар, мэдээллийг асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс файлаар авч хамтран ажилласан.

Салбарын зарим бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөртэй харьцуулахад тус үндэсний хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-120 дугаар тушаалаар батлуулсан байна.

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор, хөтөлбөрийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2019-2023 оны хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны “Төлөвлөгөө батлах тухай” А-120 дугаар тушаалаар тус тус баталсан.

Үндэсний хөтөлбөрийн зорилго

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн зорилго нь ХХАА-н үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлогын хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчилж хөгжүүлэх, төрөлжүүлэн эрчимжүүлэх, төвлөрсөн хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх, тэдгээрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахад энэ хөтөлбөрийн зорилго оршино.

Үр нөлөө

Эрчимжсэн мал аж ахуйн зохион байгуулалтыг төрөлжүүлж, кластер, ложистикийн сүлжээг бий болгоно. Импортоор авч байгаа малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг 15-100 хүртэл хувиар багасгаж, 4 хүртэлх нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг тэглэж, гадагш урсах валютын урсгалыг бууруулна. Гойд ашиг шимт мал, амьтны тоог нэмэгдүүлж, төвлөрсөн хүн амын хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн балны дотоодын үйлдвэрлэл, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлээр дамжуулан боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулж, хүнсний аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулдаг болно. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн техникийн шинэчлэлийг 50 хүртэл хувьд хүргэнэ. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эдийн засгийн үр өгөөж, орлогыг нэмэгдүүлнэ. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн болон технологийн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлж, хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах системд шилжүүлж, чадавхыг сайжруулна.

Үндэсний хөтөлбөрийн үндсэн чиглэл

Зорилт 1. Эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагааг бүсчилж, төрөлжүүлэн кластер, ложистикийн сүлжээний үйлчилгээг хөгжүүлэх;

Зорилт 2. Мал, амьтны гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг бууруулах, экспортыг дэмжих, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах;

Зорилт 3. Гойд ашиг шимт үржлийн мал, амьтны тоог нэмэгдүүлж, хот суурингийн хүн амын хүнсний хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах;

Зорилт 4. Эрчимжсэн аж ахуйн техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, бүтээмж, үр ашгийг нь нэмэгдүүлэх;

Зорилт 5. Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулах;

Зорилт 6. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачилга, хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөнгөлттэй зээл, татварын бодлогоор дэмжих;

Зорилт 7. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн технологи, эдийн засгийн мэдлэгийг сайжруулах, чадавхыг сайжруулах.

Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

- Эхний үе шат /2019-2020 он/,

- Хоёр дахь үе шат /2021-2023 он/.

Хөтөлбөрийн үр дүн

• Эрчимжсэн мал аж ахуйн зохион байгуулалтыг төрөлжүүлж, кластер, ложистикийн сүлжээг бий болгоно.

• Импортоор авч байгаа малын гаралтай зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг 15-100 хүртэл хувиар багасгаж, 4 хүртэлх нэр төрлийн бүтээгдэхүүний импортыг тэглэж, гадагш урсах валютын урсгалыг бууруулна.

• Гойд ашиг шимт мал, амьтны тоог нэмэгдүүлж, төвлөрсөн хүн амын хэрэгцээний сүү, мах, өндөг, зөгийн балны дотоодын үйлдвэрлэл, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

• Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлээр дамжуулан боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулж, хүнсний аюулгүй байдлыг бүртгэлээр баталгаажуулдаг болно.

• Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн техникийн шинэчлэлийг 50 хүртэл хувьд хүргэнэ.

• Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх эрх зүй, хөрөнгө оруулалт, татварын таатай орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эдийн засгийн үр өгөөж, орлогыг нэмэгдүүлнэ.

• Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн болон технологийн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлж, хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах системд шилжүүлж, чадавхжуулна.

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт тусгагдсан хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт 2019 оны жилийн эцсийн хэрэгжилт 78.57 хувь, үр дүнгийн үзүүлэлтийн дундаж 78.84 хувьтай тус тус үнэлэгдэв.

Хүрэх үр дүнгийн 14 шалгуур үзүүлэлтийн биелэлт 100 хувь, 3 шалгуур үзүүлэлт 70 хувь, 1 шалгуур үзүүлэлт 40 хувь, 3 шалгуур үзүүлэлтийн биелэлт 0 хувийн үнэлгээтэй байна.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин 2019 он	Хүрсэн түвшин	Үнэл -гээ	2023 он
1	Нийт мал сүрэг дэх өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувь	1.8	2.0	2.2	100	4.0
2	Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын үнийн өөрчлөлт (сая ам.доллар)	140.8	129.6	120.9	100	92.8
3	Сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн тооны өөрчлөлт (мян.толгой)	61.0	70.2	100.9	100	140.3
4	Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ (мян.литр)	134.2	161.5	168.7	100	491.1
5	Нэг үнээнээс жилд авах сүүний хэмжээ (литр)	2200	2300	2420	100	3500
6	Импортын шингэн сүүний бууралт (мян.тонн)	4.6	4.4	0	0	0
7	Импортын хуурай сүүний бууралт (мян.тонн)	25.5	24.3	25.0	40	17.9
8	Махны чиглэлийн үхрийн тооны өөрчлөлт (мян.толгой)	15.0	17.2	33.4	100	30.1
9	Гахайн тооны өөрчлөлт (мян.толгой)	35.7	36.0	21.3	0	40.0

10	Гахайн мах, өөх үйлдвэрлэлийн хэмжээ (тонн)	34.4	34.5	0	0	35.0
11	Гахайн мах, өөхний импортын хэмжээний бууралт (тонн)	4.4	4.3	4.3	100	3.8
12	Өндөг үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт (сая. ширхэг)	119.2	130.0	150.0	100	210.0
13	Өндөгний импортын бууралт (сая.ширхэг)	83.9	69.0	11.3	70	0
14	Зөгийн бүлийн тооны өсөлт (мянга)	8.1	10.6	8.9	70	24.0
15	Зөгийн бал үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт (тонн)	113.4	210.0	280.0	70	375.0
16	Зөгийн балны импортын бууралт (тонн)	216.6	191.0	87.6	700	51,6
17	Экспортолсон зөгийн балны хэмжээ (хувь)	1.0	2.0	2.1	100	10.0
18	Тэжээлийн ургамал тариалсан талбайн өсөлт (мянган га)	29.9	40.0	42.5	100	100.0
19	Хүчит тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ (тонн)	110.0	120.0	124.2	100	185.0
20	Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлсэн малын тоо (мянган толгой)	2.5	5.0	5.2	100	18.0
21	Туршлага судалсан, сургалтад хамрагдсан эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тоо	50.0	200.0	220.0	100	800.0
Дундаж үнэлгээ, %					78.57	

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан нийт 71 арга хэмжээний биелэлт дунджаар 78.84 хувьтай үнэлэгдэж (Хүснэгт 2) байна. Үнэлгээгээр 32 арга хэмжээг 100 хувь, 28 арга хэмжээг 70 хувь, 11 арга хэмжээг 40 хувийн хэрэгжилттэй байна.

д/д	Зорилт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ, хувь				Дундаж үнэлгээ
			100	70	40	0	
1	Зорилт-1	8	7	1	-	-	96.25
2	Зорилт-2	14	3	6	5	-	65.71
3	Зорилт-3	14	5	7	2	-	66.42
4	Зорилт-4	16	5	10	1	-	77.5
5	Зорилт-5	6	3	1	2	-	75.0
6	Зорилт-6	3	2	-	1	-	80.0
7	Зорилт-7	10	7	3	-	-	91.0
Нийт		71	32	28	11	-	78.84

Энэхүү үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар зорилт 1-ын хүрээнд нийт 8 арга хэмжээнээс 7 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээг 70 хувийн хэрэгжилттэй, үнэлгээний дундаж үзүүлэлт 96.2 хувь, зорилт 2-ын хүрээнд нийт 14 арга хэмжээнээс 3 арга хэмжээ 100 хувь, 6 арга хэмжээг 70 хувь, 5 арга хэмжээг 40 хувийн хэрэгжилттэй, үнэлгээний дундаж үзүүлэлт 65.71 хувьтай гарч байна. Зорилт 3-ын хүрээнд нийт 14 арга хэмжээнээс 5 арга хэмжээ 100 хувь, 7 арга хэмжээг 70 хувь, 2 арга хэмжээг 40 хувийн хэрэгжилттэй, үнэлгээний дундаж үзүүлэлт 66.42 хувьтай, зорилт 4-ын хүрээнд нийт 16 арга хэмжээнээс 5 арга хэмжээ 100 хувь, 10 арга хэмжээг 70 хувь, 1 арга хэмжээг 40 хувийн хэрэгжилттэй, үнэлгээний дундаж үзүүлэлт 77.5 хувьтай, зорилт 5-ын хүрээнд нийт 6 арга хэмжээнээс 3 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 70 хувь, 2 арга хэмжээг 40 хувийн хэрэгжилттэй, үнэлгээний дундаж үзүүлэлт 75.0 хувьтай, зорилт 6-ын хүрээнд нийт 3 арга хэмжээнээс 2 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээг 40 хувийн хэрэгжилттэй, үнэлгээний дундаж үзүүлэлт 80.0 хувьтай, зорилт 7-ын хүрээнд нийт 10 арга хэмжээнээс 7 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээг 70 хувийн хэрэгжилттэй, үнэлгээний дундаж үзүүлэлт 91.0 хувьтай тус тус гарсан байна. Тус үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт удаашралтай байгаа дараах арга хэмжээнүүд байна. Үүнд: Зорилт 2-ын 5 арга хэмжээ, зорилт 3-ын 2 арга хэмжээ, зорилт 4-ын 1 арга хэмжээ, зорилт 5-ын 2 арга хэмжээ, зорилт 6-ын 1 арга хэмжээ, нийт 11 арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байна.

ДҮГНЭЛТ

1. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтийн үнэлгээ 2019 оны жилийн эцсийн байдлаар 78.57 хувь, төлөвлөгөөний биелэлт

дунджаар 78.84 хувийн үнэлгээтэй байна. Үүнээс үр дүнтэй 32 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 28 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 11 арга хэмжээ байна.

2. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлснээр эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх замаар олон улсын жишиг, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулах чухал ач холбогдолтой тул удаашралттай байгаа арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх.

3. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд онцгой анхаарч, гадаадаас өндөр ашиг шимтэй мал, амьтан, үржүүлгийн бүтээгдэхүүн импортлох, судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг зайлшгүй шаардлагатай санхүүжилтийг төсөвт суулгах.

4. Үр дүнгийн биелэлтийг бичихдээ нэг арга хэмжээний үзүүлэлтийг хэд хэдэн арга хэмжээнд давхар тусгаж, өмнөх он, улирлын тайлан мэдээтэй харьцуулан гарсан өөрчлөлтийг дүгнэхгүй, санхүүг тусгахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

1. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 2020 оны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшинг хянаж, төлөвлөгөөг боловсруулан холбогдох газар хэлтсийн саналыг тусгаж батлуулах, хэрэгжүүлэх,

2. Салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, орон нутгийн хүрээнд хийсэн ажлуудыг тайланд тусгаж, огноо, байршилт, санхүүгийн эх үүсвэр, хэмжээг бүрэн тайлагнаж, өмнөх онуудад хийсэн ажилтай харьцуулан дүгнэлт өгөх;

**ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР
(2019 оны жилийн эцэс)**

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг чиглэл, цар хүрээ, зорилтот зах зээл, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн түвшинтэй нь уялдуулан төрөлжүүлэн ангилах, бүсчлэл тогтоох, баталгаажуулах;						
1	1.1.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд бүсчлэл тогтооно	2019-2022	Улсын төсөв: Малын төлөв байдлын үнэлгээ 289.5 сая төгрөг. Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах 44.8 сая төгрөг.		ЗГ-ын 2018 оны 131 дүгээр тогтоолоор тариалангийн бүс нутгийг тогтоож, 7 аймгийн 60 сум, 113 багийн тариалангийн бүс нутагт зөвхөн ЭМАА эрхлэх бөгөөд тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүд талбайн тодорхой хэсэгтээ тэжээл тариалж, малчдаа дэмжих зохицуулалт бий болгосон. “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд зүүн болон баруун бүсэд ЭМАА-г бүсчлэн хөгжүүлэх талаар тусгасан. Дархан-Уул аймгийн Орхон, Хонгор сумыг тариалангийн, Дорноговь аймгийн Өргөн сумын Зээгийн Хөтөлийн 40 га газрыг газар тариалан, мал маллагааны бүс нутгаар, Төв аймгийн Аргалант, Архуст, Батсүмбэр, Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэсант сумын 1,2,3,4 дүгээр багуудыг тус тус газар тариалангийн бүс нутгаар тогтоосон. Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/451 дүгээр захирамжаар “Нийслэлийн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг баталсан. Энэ хөтөлбөрийн 2.2-т Нийслэлд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтооно гэж заасны дагуу 2019 онд Нийслэл орчимд эрчимжсэн аж ахуйг цогц байдлаар хөгжүүлэх чиглэлээр суурьшлын 3 бүсийг шинээр бий болгосон. Зарим аймгууд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг Засаг даргын захирамжаар тогтоож байна. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлэх болон таван төрлийн малын үржлийн ажлын стратегийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд малыг өсгөн үржүүлэх бүс байршлыг тогтоох, бэлчээрийн болон ЭМАА-н үйлдвэрлэл явуулах чиг хандлагын талаар тусгагдсан. Зарим аймгууд ЭМАА эрхлэх бүс нутгийг Засаг даргын захирамжаар тогтоож байна.	100%
2	1.1.2. Эрчимжсэн аж ахуйнуудыг үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн ангилна	2019-2022			ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-120 дугаар тушаалаар Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулан албан байгууллага, эрчимжсэн аж ахуй	100%

					эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу 2019 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэн, биелэлтэд хяналт тавьж, эрчимжсэн аж ахуйн үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлэн ангилах чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа. 2019 онд Булган аймгийн махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхрийг Улаанбаатар хот, Дархан-Уул, Төв, Булган, Дорнод, Сэлэнгэ аймгуудад эрчимжсэн мал аж ахуйг үйл ажиллагааны чиглэлээр нь төрөлжүүлэх ажил эхлүүлэв. Төв аймагт сүүний чиглэлийн үхрийн 5, махны чиглэлийн үхрийн 2, Сэлэнгэ аймагт махны чиглэлийн үхрийн 10, Улаанбаатар хотод махны хонины 2, сүүний үхрийн 11 аж ахуйг тус тус үйл ажиллагааны чиглэлээр төрөлжүүлээд байна. Энэ ажил 2020 онд үргэлжлүүлэн хийгдэнэ.	
3	1.1.3. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх гол бүс нутгийн болон тариалангийн талбайн хил хязгаарыг тогтоох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	2019-2022			Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолоор Архангай, Сэлэнгэ, Булган, Төв, Орхон аймгийг тариалангийн бүс нутгаар тогтоосон. Тариалангийн бүс нутаг болгон тогтоосонтой холбогдуулан газар тариаланг эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Тухайлбал: Дархан-Уул аймгийн Орхон, Хонгор сум, Дорноговь аймгийн Өргөн сумын Зээгийн хөтлийн 40 га газрыг газар тариалан, мал маллагааны бүс нутгаар, Төв аймгийн Аргалант, Архуст, Батсүмбэр, Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэсант сумын 1, 2, 3, 4 дүгээр багуудыг тус тус газар тариалангийн бүс нутгаар тогтоож, газар тариаланг эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлж байна.	100%
4	1.1.5. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд усны зохистой ашиглалт, тогтвортой хэрэглээг дэмжихэд чиглэгдсэн судалгааг хийж, тухайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2019-2022			2019 онд Угтаалцайдам суманд 100 толгой махны үхрийн ферм, Аргалант суманд сүүний кластерын чиглэлийн 10 цогцолбор фермийн аж ахуй байгуулагдах үед усны зохистой ашиглалт, тогтвортой хэрэглээг дэмжихэд чиглэгдсэн судалгааг хийсэн. Улаанбаатар хот орчимд Фермерийн аж ахуйн усан хангамжийн зориулалттай шинэ худаг 5, Дархан хотод 1 худаг сэргээн засварласан.	70%
1.2. Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйг нийслэл орчмын, аймгийн төвийн, тариалангийн бүсийн гэсэн гурван чиглэл, үйл ажиллагааны түвшнээр ангилж, кластер, цогцолборын зохион байгуулалтад оруулах, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн сүү бэлтгэн нийлүүлэх тогтолцооны шинэчлэлийг дэмжих, хөгжүүлэх;						
5	1.2.2. Сүүний чиглэлийн үхрийн төрөлжсөн аж ахуйг үйл ажиллагааны түвшнээр ангилах замаар цогцолборын зохион	2019-2023			Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд төвийн бүсийн Дархан-Уул, зүүн бүсийн Дорнод аймагт сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааны талаар зөвлөгөөн зохион байгуулж, нийт 8 аймгийн 230	100%

	байгуулалтад оруулах				төлөөлөгч оролцов. Зөвлөгөөнөөр "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөрийн танилцуулга, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэх ажлыг сурталчлан таниулж, тухайн орон нутагт хийх ажлыг хэлэлцэв. Одоогоор цөөнгүй сүүний чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй фермерүүд нэг үүлдрийн бус олон үүлдэр угсааны үхрийг нэг дор маллан үржүүлж байгаа нь нэгжээс авах ашиг шим буурч, үхрийн үүлдэрлэг байдал алдагдаж байгааг анхаарах чухал асуудал болж байна. Үүний дагуу цаашдын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган анхаарч ажиллах талаар холбогдох мэдээллийг боловсруулан аймгуудад хүргүүлсэн. Үүний үр дүнд 2019 онд 9 аймгийн сүүний чиглэлийн үхрийн 23 иргэн, аж ахуйн нэгжийн үхрийг төрөлжүүлэн үйл ажиллагааны түвшнээр ангилах замаар төрөлжүүлж, 11 аж ахуй цогцолборын зохион байгуулалтад орсон байна.	
6	1.2.3. Сүүний фермерийн стандартыг тогтоох,	2019-2023			Нийслэлийн ХХААГ-тай хамтран сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавигдах ерөнхий шаардлага үндэсний стандартын төслийг боловсруулан Стандарт хэмжил зүйн газрын Стандартчиллын Үндэсний зөвлөлийн 2018 оны 5 сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. "Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS6723:2018 МУ-ын стандартыг нийтэд хүргэх, сурталчлах ажлыг зохион байгуулж, Нийслэлийн мал бүхий дүүргийн албан байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, сүүний үхрийн фермерийн аж ахуй эрхлэгчид 300 гаруй иргэнд хүргүүлж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.	100%
1.8. Эрчимжсэн аж ахуйд сүрэг сэлбэх үржлийн гойд ашиг шимт хээлтэгч, эх сүргийг нийлүүлэх чиглэлээр дагнасан үржлийн аж ахуй эрхлэгчид олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;						
7	1.8.1. Эрчимжсэн аж ахуйд чиглэл тус бүрт сүрэг сэлбэх үржлийн гойд ашиг шимт мал нийлүүлэх үржлийн аж ахуйнуудыг бий болгоно	2019-2023	ЖДҮХС-ийн зээл 3.7 тэрбум, Хувийн хэвшил 3 тэрбум, Орон нутгийн төсөв 0.5 тэр бум төгрөг.		ХХААХҮ-ийн сайдын тушаалаар "Үржлийн малд хянан магадалгаа хийх, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих" журмын дагуу шинээр үүлдэр, омгоор баталгаажсан малын үржлийн ажлын 5-10 жилийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлуулж, үүний хүрээнд үржлийн хээлтүүлэгчийг мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтаар ялган төвлөрүүлж, бүс нутагтаа сайжруулагчаар ашиглах, цөм сүргийн малын тоог нэмэгдүүлэх асуудлыг тусган ажиллаж байна. 2019 онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Уудам жаргалант" ХХК, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд "Цагаан уул арвин сүрэг" ХХК тус тус байгуулагдан үржлийн хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлж, мэргэжлийн ажил үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж	100%

					байна. Цэвэр үүлдрийн үхрийн аж ахуй эрхэлдэг "Нүүдэлчин" ХХК нь 2019 оны эхний хагаст 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 үнээний 2 кластер ферм байгуулсан байна. ЖДҮХС-аас 2019 онд сүү, махны үхрийн аж ахуйг өргөжүүлэн хөгжүүлэх, үйл ажиллагааг бэхжүүлэхэд зориулж 39 төсөлд 3.7 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлснээр сүрэг сэлбэх үржлийн гойд ашиг шимт мал худалдан авахад маш том дэмжлэг боллоо. Дархан-Уул аймаг орон нутгийн төсөвт үхрийн аж ахуйн суурьшлын бүс байгуулахад шаардлагатай 500 сая төгрөгийг тусгаж Булган аймгаас Сэлэнгэ үүлдрийн 100 толгой хээлтэгч худалдан авч үржлийн аж ахуй байгуулав.	
1.9. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид бэлчээр, хадлангийн газар, таримал тэжээл тариалах тариалангийн талбайг гэрээгээр ашиглуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах.						
8	1.9.2. Бэлчээр дэх өвс, ургамлын бүтэц, тархац, ургац, ус, тэжээлийн нөөцийн урьдчилсан судалгааг хийж, эрчимжсэн мал аж ахуй, түүнд суурилсан үйлдвэрлэлийг бүсчилсэн, эсхүл хэсэгчилсэн хэлбэрээр хөгжүүлэх чиглэл, бүсийг тогтооно.	2019-2020			Монгол орны бэлчээрийн ургамлын бүтэц, тэжээлийн зэрлэг ургамлын биологийн идэвхт нэгдлийн судалгаа хийх зөвлөх үйлчилгээгээр Дорнод аймгийн Матад, Халх гол сум, Сүхбаатар аймгийн Асгат, Түмэнцогт, Дарьганга сумын бэлчээрийн ургамлын төрөл, зүйлийн бүрдлийг зун, намрын улиралд тодорхойлж, талбайн ургацын судалгаа хийж, ургамлын тэжээллэг чанар (уураг, өөх тос, нүүрс ус, эслэг) болон малын идэх идэмжийг харьцуулан судалсан. Судалгаагаар хавар эрт цухуйж, эцэж, доройтсон мал идэж хурдан тэнхэрдэг ач холбогдолтой олон зүйл ургамал байгаа нь тухайн бэлчээрийн тэжээлийн нөөц сайтайг илтгэнэ. Сумын удирдлага, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх, малын хөлөөс ээлжлэн чөлөөлж, доройтохоос хамгаалж, байгалийн хадлан бэлтгэх зөвлөмжийг боловсруулан хүргүүлсэн. Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын Баян нурууны отрын бүс нутгийн 102.5 мянган га бэлчээрийн талбайн төлөв байдлын үнэлгээ хийв. ХХААХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалыг батлуулж, холбогдох албан байгууллага, хүмүүст хүргүүлэв. Баян-Өлгий аймаг, сумын МАА-н асуудал, цаг уурын асуудал эрхэлсэн албан тушаалтан, ЭМАА эрхлэгчдэд бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалын сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангав.	100%
2.1. Шингэн сүү, сүүн бүтээгдэхүүн, үхрийн хөлдүү мах, өндөг, гахай, шувууны мах, өөх, зөгийн балны импортыг үе шаттайгаар бууруулах, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг мэргэжлийн холбоодтой хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх;						
9	2.1.1. Шингэн сүү, сүүн бүтээгдэхүүнийг	2019-2023			Сүүний хангамж нэмэгдэж байгаа боловч сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл, хэрэгцээт сүүний 85 хувийг	40%

	импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.				уламжлалт аргаар, 15 хувийг үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүгээр хангаж байна. Энэ нь үйлдвэрт зөвхөн эрчимжсэн аж ахуйгаас үнээний сүү нийлүүлж, үлдсэн малын сүүг уламжлалт цагаан идээ бэлтгэх, тухайн орон нутгийн хүн амын ундны сүүний хэрэгцээг хангахад зарцуулж байгаатай холбоотой юм. Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ нийт нийлүүлэлтийн 84.3 хувийг бүрдүүлж байгаа боловч зөвхөн улирлын чанартай байгаа тул өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын сүүний хэрэгцээг бүрэн хангах нөхцөл, боломж бүрдэхгүй байна. Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх нийт сүүний хэмжээ сэрүүний улиралд 35%, дулааны улиралд 65%-ийг бүрдүүлж байна. Хот суурин газрын хүн амын хэрэгцээг шингэн сүүгээр хангаж чадахгүй байгаа тул дотоодын аж ахуйн нэгжүүд хуурай сүү импортлон үйлдвэрлэлдээ ашиглаж байна. Өвөл, хаврын улиралд хот, суурин газрын хүн амын 85 хүртэл хувь нь импортын хуурай сүү сэргээж үйлдвэрлэсэн шингэн сүү хэрэглэж байна. Цаашдаа эрчимжсэн аж ахуйг дэмжих нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. Монгол Улсын Засгийн газраас, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар 2-ын хоорондын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр манай орны газар тариалангийн бүс нутагт 600 үнээ бүхий 10 сүүний эрчимжсэн ферм байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, тендерийн баримт бичгийг боловсруулж байна. 2020 онд тендер шалгаруулалтыг зохион байгуулна.	
10	2.1.2. Эрчимжсэн үхрийн аж ахуйн махны экспортыг нэмэгдүүлэх, үхрийн хөлдүү махны импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	2019-2023			2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар хонь, ямааны түүхий мах 7041 тн, адууны мах 30835 тн /квотын гүйцэтгэл 99.5%/, дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн 18421 тн, дайвар бүтээгдэхүүн 2358 тн тус тус үйлдвэрлэн бэлтгэж, нийт 58655 тн мах, махан бүтээгдэхүүнийг экспортолсон байна. Цаашид мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.	70%
11	2.1.3. Шувууны мах, өндөгний импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	2019-2023			2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр шувууны махны хувьд дотоодын үйлдвэрлэл 85000 тн, импорт 13200 тн, хангамжийн түвшин 257 хувь, импортын хамаарал 13.4 хувь байна. Өндөгний хувьд дотоодын үйлдвэрлэл 8900 тн, импорт 8000 тн, хангамжийн түвшин 88 хувь, импортын хамаарал 47.3 хувь байна. Цаашид шувууны мах, өндөгний импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх чиглэлд анхаарч байна.	40%

12	2.1.4. Гахайн мах, өөхний импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	2019-2023			2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр гахайн мах 2050.3 тн, өөх 1466.3 тн-г импортолсон байна. Гахайн мах, өөхний импортыг бууруулах төлөвлөгөөг баталж хэрэгжүүл ажлын хугацаа болоогүй тул 2020 онд үргэлжлүүлэн ажиллана.	40%
13	2.1.5. Зөгийн балны импортыг бууруулах, экспортыг нэмэгдүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжүүлнэ.	2019-2023			Зөгийн балны импортыг бууруулах, экспортыг нэмэгдүүлэх, үлдэгдлийг хянах төлөвлөгөөг Европын холбооны бусад улс орнуудад тавих шаардлагын дагуу боловсруулан ЕХ-ны Хүнсний аюулгүй байдлын газарт хүргүүлсэн. Зөгийн баланд малын эмийн болон пестицидийн үлдэгдлийг тодорхойлох лабораторийн хүчин чадлыг бэхжүүлэх талаар ажиллаж байна.	70%
14	2.1.6. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиг хандлагын судалгааг хийнэ.	2019-2020	Нийт 397,7 сая төгрөг. Үүнээс Улсын төсөв: 289,5 сая төгрөг. Гадаад төсөл: 40873 USA \$ буюу 108.3 сая төгрөг.		Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөөг боловсруулан 2020 оны 1 сарын 15-ны өдрийн ХХААХҮ сайдын А-15 дугаар тушаалаар баталж, төлөвлөгөөнд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиг хандлагын талаар тусгагдсан байгаа. Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг гүйцэтгэж, цаашид авах арга хэмжээний саналыг 7 багц болгон нэгтгэж, үүний хүрээнд зах зээлийн эрэлтэд мал аж ахуйн салбарын бүтээмж, чадварыг нийцүүлэх, мал, малын гаралтай бүтээгдэхүүний эдийн засгийн эргэлтийг түргэсгэх арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх боломж нээгдэж байна гэсэн дүгнэлтийг гаргаж, төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг төрийн бодлогоор тогтоож, ашиг шимийн чиглэлээр сонгон үржүүлэх, генетик нөөцийг бататган сайжруулах нь зүйтэй гэсэн зөвлөмжийг УИХ-д танилцуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.	70%
2.2. Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэл, технологийн түвшинг сайжруулан, гойд ашиг шимт үхрийн тоог нэмэгдүүлэх, зохиомол хээлтүүлгийн цар хүрээг тэлэх арга хэмжээг хэрэгжүүлж, дотоодын шингэн сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөх, импортын шингэн болон шар сүүг 100 хувиар халж, цөцгийн тос, аарц тараг зэрэг сүүн бүтээгдэхүүний импортыг 30 хүртэл хувиар бууруулах;						
15	2.2.1. Сүүний эрчимжсэн одоо ажиллаж байгаа аж ахуйнуудыг холдинг компанид нэгдэн хөгжихийг дэмжих замаар дотоодын сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	2019-2023			Сүүний эрчимжсэн аж ахуйн хөгжлийн гарц бол “Үр дүнтэй иж бүрэн түншлэлд тулгуурлан дэвшилтэт технологи нэвтрүүлэх” зорилгоор түүхий сүү үйлдвэрлэх нэмүү өртгийн хүрээнд кластер хоорондын иж бүрэн түншлэл “Холдинг компани” хэлбэртэй байх нь зөв гэж үзэн Монголын сүүний нэгдсэн холбоо ТББ, фермерүүд хамтран байгуулахаар ажиллаж байна. Холдинг компанийн хүрээнд иж бүрнээр түншлэн дэвшилтэт технологи нэвтрүүлэх төслийн эдийн засгийн тооцоо хийсэн байна. Төсөлд хамрагдах эсэх тандалт судалгаанд саалийн 500 гаруй ферм хамаарч 87.5 хувь төсөлд оролцох хүсэлт илэрхийлсэн байна. Төслийг нийт 30000 үнээ бүхий 1000 ферм хамруулан гүйцэтгэхэд 70 тэрбум,	70%

					харин гарааны төслийг 3000 үнээ бүхий 100 ферм хамруулан хэрэгжүүлэхэд 7,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн тооцоо гарсан байна. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд жишиг сүүний үйлдвэр байгуулах төслийг бодлогоор дэмжиж, хоногт 5 тн сүү боловсруулах хүчин чадалтай 2 үйлдвэр ашиглалтад бүрэн орж, орон нутгийн сүүний нөөцийг ашиглан импортыг орлох, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлээд байна. Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ нийт нийлүүлэлтийн 84.3%-ийг бүрдүүлж байгаа боловч сэрүүний улиралд 35%, дулааны улиралд 65%-ийг бүрдүүлж байгаа ч хот, суурин газрын хүн амын шингэн сүүний хэрэгцээг бүрэн хангахгүй байна. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан малын сүү үйлдвэр, цехэд нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн механизмыг бий болгох, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх, сүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор сүүний урамшууллын журмын төслийг боловсруулж байна.	
16	2.2.2. Хуурай сүүний импортын татварыг боломжит дээд хэмжээнд хүргэж нэмэгдүүлж тогтооно	2019-2023			Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх сүүний хэмжээ нийт нийлүүлэлтийн 84.3 хувийг бүрдүүлж байгаа боловч зөвхөн улирлын чанартай байгаа тул өвөл, хаврын улиралд төвлөрсөн хот, суурин газрын хүн амын сүүний хэрэгцээг бүрэн хангах нөхцөл, боломж бүрдэхгүй байна. Эрчимжсэн аж ахуйгаас нийлүүлэх нийт сүүний хэмжээ сэрүүний улиралд 35%, дулааны улиралд 65%-ийг бүрдүүлж байна. Хот суурин газрын хүн амын хэрэгцээг шингэн сүүгээр хангаж чадахгүй байгаа тул дотоодын аж ахуйн нэгжүүд хуурай сүү импортлон үйлдвэрлэлдээ ашиглаж байна. Өвөл, хаврын улиралд хот, суурин газрын хүн амын 85 хүртэл хувь нь импортын хуурай сүү сэргээж үйлдвэрлэсэн шингэн сүү хэрэглэж байна. Иймд одоогоор импортын татварыг нэмэгдүүлэх боломж бүрдэхгүй байна.	40%
17	2.2.3. Шингэн сүү, сүүн бүтээгдэхүүний импортын хэмжээг бууруулна.	2019-2023			Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, сүү, сүүн бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортыг дэмжих зорилтуудыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-313 тоот тушаалын дагуу сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох хууль эрх зүйн орчныг бий болгох, импортлогч улсын холбогдох эрх бүхий байгууллагын хийх эрсдэлийн хянан	70%

					магадалгааг зохион байгуулж БНХАУ-ын төлөөлөгчдийг хүлээн авч, экспортын эрх зүйн баримт бичгийг төслийг боловсруулах ажлыг зохион байгуулсан. БНХАУ-ын төлөөлөгчид 4 хүний бүрэлдэхүүнтэй манай улсад 6 хоног ажилласан. Уг төлөөлөгчид хөтөлбөрийн дагуу МЭЕГ, МХЕГ, УМЭАЦТЛ болон сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Витафит милк”, “Милко”, “Маку”, “Айс марк” ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, “Баян симментал”, “Хишигтэн нүүдэлчин” фермийн үйл ажиллагаатай тус тус танилцсан. БНХАУ-аас эрсдэлийн хянан магадалгаа хийсэн төлөөлөгчид Монгол Улсаас сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг дүгнэж хариу ирүүлэхээр болсон.	
18	2.2.4. Сүү, сүүн бүтээгдэхүүний импортыг бууруулна.	2019-2023			Төвлөрсөн хот суурин газрын сүүний хэрэгцээг тогтвортой хангах, улирлын хамаарал, импортыг бууруулах зорилгоор гарал үүсэл нь баталгаажсан, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан мал, сүүг үйлдвэр, цехэд нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх эдийн засгийн механизмыг бий болгох, үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлэх, сүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор сүүний урамшууллын журмын төслийг боловсруулсан. Журмын төслийг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн зөвлөлд 3 удаа чиглэл авсны дагуу яамдаас санал авахаар ажиллаж байна.	40%
2.3. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн технологийн эрчимжүүлэлтийг дэмжиж, махны экспортын бодлогод нийцүүлэн мал бордох үр ашигтай аргачлал, технологийг нэвтрүүлж мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үхрийн хөлдүү махны импортыг бүрэн халж, махны экспортыг 30.0 хувиар нэмэгдүүлэх;						
19	2.3.3. Үхрийн хөлдүү махны импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлнэ	2019-2023			2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар: Хонь, ямааны түүхий мах 7041 тн Адууны мах 30835 тн /квотын гүйцэтгэл 99.5%/ Дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн 18421 тн Дайвар бүтээгдэхүүн 2358 тн Нийт 58655 тн мах махан бүтээгдэхүүн экспортолосон байна.	70%
2.4. Шувууны аж ахуйн технологийн түвшин, эрчимжүүлэлтийг сайжруулах, сүрэг сэлбэх хэрэгцээнд дэгдээхэй нийлүүлэх үржлийн аж ахуйд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын өндгийг 90 хувь, шувууны махыг 30 хувиар бууруулах;						
20	2.4.1. Шувууны аж ахуйн технологийн түвшин, эрчимжүүлэлтийг дэмжиж, шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2019-2023			Манай улсын дотоодын шувууны аж ахуй эрхлэгчдийн технологийн төвшин ОУ-ын зэрэгт хүрсэн. Хэрэглэгчдийн өндөгний хэрэгцээ өссөн өнөө үед үйл ажиллагаа олон жил явуулж буй жижиг, дунд фермийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлагатай болсон. Судалгаагаар 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 300 сая ширхэг өндөг хэрэглэсэн ба үүний 50% буюу 150 сая ширхгийг ОХУ-аас импортоор авсан байна. Үлдсэн 150 сая ширхэг өндгийг дотоодын шувууны аж ахуй эрхлэгчид үйлдвэрлэсэн байна. Хот суурин	100%

					газрын хүн амын төвлөрөлтэй холбоотойгоор өндөгний хэрэглээ жил бүр өсөж байгаагаас импортын хэмжээ, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ хамтдаа өсөж байна. Тахианы тоо өмнөх оны төвшнөөс 15%-иар нэмэгдэж 956.0 мянга болсон. Махны чиглэлийн тахианы 1 аж ахуй үйл ажиллагаа явуулж байна. Шувууны аж ахуйн тэжээлийн 2 үйлдвэр үйл ажиллагаа явуулж, түүхий эдийнхээ 80 орчим хувийг дотоодоос, 20 орчим хувийг импортоор хангаж байна. Импортоор авдаг гол түүхий эд нь эрдэнэ шиш, шар буурцаг, амин хүчлүүд байна.	
2.6. Зөгийн аж ахуйн зохион байгуулалт, үйлдвэрлэлийн технологийн түвшин, зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулан дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах ажлыг мэргэжлийн холбоотой хамтран гүйцэтгэж, зорилтот зах зээлд бэлтгэн нийлүүлэх зөгийн бал, бусад дагалдах бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэн, импортын зөгийн балыг 70 хувиар бууруулах;						
21	2.6.1. Зөгийн аж ахуйн зохион байгуулалтыг сайжруулна	2019-2023			Мон Апи кластер нь жилдээ 150-180 тонн зөгийн бал хураан авах хүчин чадал бүхий анхны байгууллага боллоо. Тус кластерын үндсэн зорилго нь зөгийн аж ахуй эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлснээр тэдэнд өрхийн үйлдвэрлэлээс арилжааны шинжтэй бизнесийг эрхлэхэд дэмжлэг үзүүлж зөгийн салбар дахь бизнесийн төрлийг олшруулах, өргөжүүлэх, зөгийн бүтээгдэхүүний борлуулалтын боломжуудыг бий болгосноор тэдний ашиг орлогыг нэмэгдүүлэхэд оршино. Манай улсын 10 аймгийн 17 суманд байрших 38 зөгийн аж ахуй хамрагдсан. Үүнд: Өвөрхангай 1, Булган 3 Дархан уул 11, Дорнод 2, Орхон 3, Төв 4, Сэлэнгэ 8 Хөвсгөл 1, Хэнтий, УБ-2 зөгийн аж ахуй болно. Зөгийн аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд зөгийчдийн мэдлэгийг дээшлүүлж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжүүлэхээр 6 хүний бүрэлдэхүүнтэй баг Канад улсын Монреал хотод зохион байгуулсан “APIMONDIA-46” их хуралд 2019 онд оролцож, үзэж мэдсэн туршлагаа зөгийчдөд зөвлөж байна. 2019 онд ЖДҮХС-гаас зөгийн 1 аж ахуйд 281 сая төгрөгийн зээл олгов. Азийн хөгжлийн банкны "Хөдөө аж ахуйн өртгийн сүлжээг дэмжих төсөл"-ийн хүрээнд 5 аймгийн 40 аж ахуйн нэгжид 1548 зөгийн гэр, 268 зөгийн эмж буцалтгүйгээр олголоо. Төслийн хүрээнд нийлүүлж байгаа тоног төхөөрөмж болон техник туслалцааны хүрээнд Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлд “Зөгийн эрүүл мэнд, эм судалгааны төв”-ийг байгуулж 2019 оны 5 дугаар сарын 21-нд нээлтээ хийлээ. Тус төвийг байгуулснаар дараах давуу тал бий болсон юм. • Зөгийн эрүүл мэндэд чиглэсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажил өргөжих, эрчимжих нөхцөл бүрдсэн, • Варроа хачгийн эсрэг үйлчилгээтэй эмүүдийн	100%

					<p>үйлдвэрлэлийн хэмжээ өмнөхөөс 2-3 дахин нэмэгдэх буюу нийт хэрэгцээний 80-аас дээш хувийг хангах боломж бүрдэж, үйлдвэрлэлийн технологи сайжирсан,</p> <ul style="list-style-type: none"> • Бусад өвчний үед хэрэглэх шинэ эмүүдийн технологи бий болсон, • Зөгийн аж ахуйн малын эмч мэргэжилтнүүдэд мэдээлэл хүргэх, тэднийг дадлагажуулах боломжтой болсон. 	
22	2.6.3. Зөгийчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах	2019-2023			<p>ОУ-ын зөгийн аж ахуйн стандарт бүхий 1000 гаруй зөгийн гэрийг Зөгийн аж ахуй эрхлэгчдэд хүлээлгэн өгч, зөгийн бүлийн арчилгаа маллагааны технологийн дагуу боловсруулсан алсын зай видео сургалтын “Зөгийн бүлийг өвөлжөөнөөс гаргах, хаврын арчилгаа”, “Зөгийн бүлийн зуны арчилгаа, Бүлэнцэр бүрдүүлэх, Бал хураах технологи”, “Зөгийн бүлийг намрын арчилгаа, өвөлжүүлэх технологи”, “Зөгийн аж ахуйн зохион байгуулалт”, “Зөгийн өвчин, ариутгал, халдваргүйжүүлэлт”, сэдэвт контент бэлтгэсэн. Сургалтын видео контент тус бүр нь 4-10 минутын урттай 15 бүлгээс бүрдсэн алсын зайн видео сургалт болно. “Зөгийн аж ахуйн зохистой дадал” нэвтрүүлэх зорилгоор зөгийн аж ахуйн эрхлэгчдэд 3 сарын сургалт зохион байгуулж, гарын авлага боловсруулав. Зөгийчдийн ур чадварыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадлыг дээшлүүлэх чиглэлээр төслөөс олон шаталсан сургалтыг зохион байгуулав. Зөгийчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэн, “мэргэжлийн гэрчилгээ”-г олгох эрх бүхий тусгайлсан сургалт (6 модуль)-д зохион байгуулав. Төслийн хүрээнд явуулсан сургалтад үнэлгээ хийж харьцуулахад, хөтөлбөрийн 83% буюу 4 модулийг хангасан байна. Иймд үлдсэн сургалт (2 модуль)-ыг зохион байгуулах, зөгийчдөд ур чадварын үнэмлэх олгох зорилгоор Монголын зөгийн сантай хамтран “Зөгийчдийн ур чадварыг дээшлүүлж, мэргэжлийн гэрчилгээ олгох сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгүүлэх, санхүүжүүлэх” 2019/05/04 гэрээ байгуулан 2019 оны 6 сараас 8 сарыг дуустал хугацаанд амжилттай зохион байгуулсан.</p>	100%
3.1. Сүүний чиглэлийн цэвэр үүлдрийн 3600 хээлтэй гунж, хосолмол ашиг шимт 2200 хээлтэй гунжийг импортлон нутагшуулах, тэдгээрийн үр төлд удам зүйн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгуулага, холбоодын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж, сүүний үхрийн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг хөгжүүлэх						
23	3.1.2. Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй, тэдгээрт үржүүлж байгаа үхэр сүргийг бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулна.	2019-2023			<p>2019 оны хэмжээнд сүүний үхрийн гарваль ашиг шимийн бүртгэл мэдээллийн санд 32 аж ахуй нэгж иргэний 400 тоо толгой үнээ, гунжийг хамруулан шинээр бүртгэлд оруулав. 2019 онд нийт 12500 үнээ, гунжны өглөө, оройн саамын хэмжээ, чанарын мэдээг авч, нийт 12485 дээж шинжилгээнд хамруулж мэдээллийн санд баяжуулалт хийв. Үржилд</p>	70%

					ашиглаж буй хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч малыг ялган тэмдэглэх, малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг 7 аймаг, нийслэлийн ХХААГ-тай гэрээ байгуулж, 95.7 мянган толгой малд гүйцэтгэхээр төлөвлөв. Үүний дагуу нийт 10.2 мянган үржлийн бухыг ялган тэмдэглэж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж байна. Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн гоц халдварт өвчингүй, эрүүл бүсэд хамаарах Баянзүрх, Хан-Уул, Сонгино хайрхан, Налайх дүүргүүдэд байгаа 35.0 мянган үхрийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулав.	
3.2. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйд махны хэмжээ, гарцыг нэмэгдүүлэх үржил селекцийн ажлыг явуулж, гадаадаас авчирсан махны чиглэлийн гойд ашиг шимт үхэр, хонины тэжээллэг, арчилгаа, маллагааны технологийг мөрдүүлж, удам зүйн үнэлгээгээр шалгарсан үржлийн өсвөр бухыг бойжуулах, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хамрах хүрээг тэлэх, бүсчлэлийн бодлогоор махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;						
24	3.2.2. Удам зүйн үнэлгээгээр шалгарсан махны чиглэлийн үржлийн өсвөр бух, хуцыг бойжуулах, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжинэ.	2019-2023			Малын удмын сангийн үндэсний төвийн малын үрийн Үндэсний генийн сангийн хэрэгцээнд 2019 оны байдлаар сардаа 150-200 литр, жилийн хэрэгцээнд нийт 2280 литр, үр үйлдвэрлэл, үржүүлгийн техникч нарт 200 литр, нийт 2480 литр азот үйлдвэрлэн үйлчилгээнд ашиглав. Аймаг, нийслэлийн 12 мал үржүүлгийн техникч нартай гэрээ байгуулан ажлыг дүгнэн ажиллаж байна. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, гэрээт техникч нарын захиалгын дагуу сүү, мах, мах-сүүний хосолмол ашиг шимт чиглэлийн бухын 1455 тун үр, сүүний үхрийн 305 тун үр, махны үхрийн 915 тун үр, Эдельбай хуцын 50 тун хөлдөөсөн үрийг малын үндэсний генийн сангаас нийлүүлэн ханган ажиллав.	100%
25	3.2.3. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйн хамрах хүрээг бүсчлэлийн бодлогоор тэлж, эрчимжүүлэлт, кластерыг хөгжүүлнэ.	2019-2023			ЖДҮХС-ийн эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр Улаанбаатар хотод 13 төсөл, орон нутагт 28 төслийг сонгон шалгаруулж 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт хамрагдсан эрчимжсэн мал аж ахуй эрхлэх нийт 41 төслийн 85 хувь буюу 35 төсөл үйл ажиллагаагаа өргөжүүлж, 15 хувь буюу 6 төсөл шинээр үйл ажиллагааг эхлүүлж, нийт 98 ажлын байр хадгалагдан үлдэж, 198 ажлын байр шинээр бий болгохоор төлөвлөсөн. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр санхүүжилт авсан нийт төслийн 51.22% нь сүүний үхэр, 29.27% нь махны үхэр, 14.63% хувь нь мах, сүүний хосолсон чиглэлээр, 4.88% нь зөгийн аж ахуйн чиглэлээр тус тус үйл ажиллагааг явуулж байна. Үүнээс шувууны аж ахуй эрхлэх чиглэлээр ЖДҮХС-аас УБ хотод 2 төсөл, орон нутагт 5 төслийг сонгон шалгаруулж нийт 1.3 тэрбум төгрөгийн урт хугацаатай,	100%

				хөнгөлөлттэй зээлийг олгосон. Төслийн хүрээнд тахианы аж ахуйн 7 төсөл үйл ажиллагаагаа өргөжүүлж, үүний үр дүнд 36 ажлын байр хадгалагдсан үлдэж, 40 ажлын байр бий болно. Үр дүнд нь махны чиглэлийн үхрийн тоо 2019 онд 33.7 мянга болж өмнөх оноос 9.9 мянга буюу 29.4%-иар өссөн байна. Дорнод аймгийн Халхгол, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд үржүүлж Дорнод Монголын улаан үхрийг ХХААХҮ-ийн сайдын А-507 дугаар тушаалаар үүлдэрээр баталж, 10800 толгой цэвэр махны чиглэлээр тухайн бүс нутагт нь үржүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. “Тайшир-Өргөө” ХХК-ийн 2017 онд Франц улсаас импортолсон Суффолк, Меринос, Беришон душер, Романов үүлдрийн нийт 657 толгой хонийг үржүүлэн кластерыг хөгжүүлж эхлээд байна. 2019 онд бүсчлэлийн бодлогоор Дорнод аймагт махны чиглэлийн Казакын цагаан толгойт 5105 толгой үхэр буюу нийт үхрийн 1.8%-ийг эзэлж байна. Үүнээс Баян-Уул суманд Казакын цагаан толгойт үүлдрийн үхэр 4609 толгой буюу нийт Казакын цагаан толгойт үхрийн 90.2%-ийг өсгөн үржүүлж байна. Махны чиглэлийн Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр 5696 толгой буюу нийт үхрийн 2%, үүнээс Халхгол суманд Дорнод Монголын улаан үүлдрийн үхэр 5002 толгой буюу 87.8%-ийг өсгөн үржүүлж байна.	
3.3. Өндөгний болон махны чиглэлийн тухайлсан үүлдрийн үржлийн 20,0 мянган өндгийг импортлох, хоногийн настай дэгдээхэйг бойжуулж аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээнд нийлүүлэх үржлийн аж ахуйг бий болгох, өндөгний чанар, баталгаажуулалт, импортын өндөгний хяналтыг сайжруулах чиглэлээр мэргэжлийн байгууллага, холбоод хамтын ажиллагааг нягтруулж, үржлийн аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл бэлтгэн нийлүүлэх сүлжээ бүхий шувууны аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;					
26	3.3.1. Бодлогын түвшинд цэвэр үүлдрийн тахианы үржлийн өндөг импортлоно.	2019-2023		ЭМАА-н хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд шувууны аж ахуйн арчилгаа маллагаа, технологийн түвшин, эрчимжүүлэлтийг сайжруулах, сүрэг сэлбэх хэрэгцээнд дэгдээхий нийлүүлэх үржлийн аж ахуйд бодлогын дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн шувууны мах, өндөг үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортын өндөгний хувийг бууруулах талаар тусгав. 2017 оны жилийн эцсийн өндөглөгч тахианы тоо толгойг 2018 онтой харьцуулахад 300 гаруй мянган толгой буюу 30 гаруй хувиар нэмэгдэж байгаа нь өндөгний импортыг 13 хувиар бууруулах бүрэн боломжтой гэж үзсэн. Харин 2018 онд 135.8 сая ширхэг өндөг, 2019 онд 150 сая ширхэг өндөг импортолж өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 14.2 сая ширхэг өндөг буюу 9.5%-иар өссөн байна. Улсын хэмжээнд 2019 онд 300 сая ширхэг өндөг хэрэглэсэн ба үүний 50 хувь буюу 150 сая ширхгийг ОХУ-аас импортоор, 150	40%

					сая ширхэг өндгийг дотоодын шувууны аж ахуй эрхлэгчид үйлдвэрлэсэн байна. Өндөгний хэрэглээ жил бүр өсөж байгаа бөгөөд импортын хэмжээ, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ хамтдаа өсөж байгаа нь төв суурин газрын хүн амын өсөлт, уг бүтээгдэхүүний хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбоотой байна.	
27	3.3.2. Хоногийн настай дэгдээхийг бойжуулах, нийлүүлэх үржлийн аж ахуйг бий болгоно	2019-2023			Түмэн шувуут ХК хоногийн настай дэгдээхий бойжуулах, нийлүүлэх үржлийн аж ахуй байгуулах төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулав. 2019 онд тус компани 25.0 мянган толгой хоногийн настай дэгдээхийг өөрийн инкубатортаа бойжуулан 5 аж ахуйд сүрэг сэлбэхээр худалдаалсан бөгөөд сардаа 100.0 мянган үржлийн өндөг өөрийн инкубатортаа бойжуулан хоногийн настай дэгдээхий бойжуулах боломжтой болсон. Гэвч худалдан авах зах зээл хомс байна. Эх сүргийн үржлийн аж ахуй бий болгохын тулд эхний ээлжид төрөөс үржлийн өндөгний татварыг тэглэж байж хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд аж ахуйд хямд өртгөөр үржлийн өндөглөгч тахиа нийлүүлэх боломж бүрдэнэ. Иймд ойрын 2 жилд үржлийн өндөг импортолж хоногийн настай дэгдээхий бойжуулах, зах зээлд борлуулах боломжтой байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар манай улс нийт 956.0 мянган толгой өндөглөгч тахиаатай байна.	70%
28	3.3.5. Шувуунд зориулсан тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортын шувууны тэжээлийг бууруулна.	2019-2023			Манай улсад шувууны тэжээл үйлдвэрлэдэг 2 аж ахуй үйл ажиллагаа явуулж, шувууны тэжээл үйлдвэрлэлийн 95 хувийг хангаж байна. Эдгээр үйлдвэрүүд шувууны тэжээлд дотоодын улаан буудай, хивэг, рапс, тос, мах ясны гурил, шохойн чулуу зэргийг хэрэглэхээс гадна импортоор шар буурцагны шахдас, эрдэнэ шиш худалдан авч байна. Тэжээл үйлдвэрлэлийн дотоодын компаниудын тэжээлийг НӨАТ-с чөлөөлсөн нь сайн тал ч тэжээлийн үйлдвэрт тушаасан улаан буудайн урамшуулалд хамаарахгүй байгаа нь түүхий эд нийлүүлэгчдэд хүндрэл болж байна. 2018 онд шувууны бүрэн найрлагат тэжээл 11215.4 тн-ийг импортолж байсан бол 2019 онд 3060.4 тн-ийг импортолж, шувууны тэжээлийн импорт 3.6 дахин буурсан байна.	100%
3.4. Цэвэр үүлдрийн 1000 мэж, 50 бодонг Европын Европын бүсээс импортлон гахайн аж ахуйд үржлийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлэн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж аж ахуйн нэгжүүдийн сүрэг сэлбэх хэрэгцээг хангах, зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ үзүүлэх, бүртгэлжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллага, холбоод хамтран хэрэгжүүлэхийг дэмжиж, үржлийн аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл бэлтгэн нийлүүлэх сүлжээ бүхий гахайн аж ахуйн эрчимжүүлэлт, кластерыг дэмжин хөгжүүлэх;						
29	3.4.1. Бодлогын түвшинд Европын бүсээс цэвэр үүлдрийн үржлийн гахайг импортлоно.	2019-2023			Улсын хэмжээнд 2020.01.01-ний байдлаар 144 аж ахуйн нэгж, 587 өрхөд 21346 толгой гахай тоологдсон нь өмнөх оны төвшнөөс 37.9% буюу 8096 толгой гахайгаар цөөрсөн. Энэ нь 2019 онд гахайн өвчин гарч 3000	40%

					<p>гаруй гахайд устгал хийсэнтэй холбоотой. Нөгөө талаар энэ төрлийн үржлийн аж ахуй байхгүйгээс сүрэг сэлбэх боломжгүй, үүлдэрлэг байдал алдагдах, ашиг шимийн түвшин буурах, төрөл бүрийн өвчин эмгэгт өртөх зэрэг эмзэг байдал бий болоод байна. Гахай үржүүлэгчид гахайн аж ахуйн үржлийн ажлыг сайжруулах санаачлаг гаргах боловч хөрөнгө, зээлийн дутагдалтай байдлаас шалтгаалан тэдний асуудал шийдэгдэж чадахгүй байна. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр батлагдан, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө ХХААХҮ-ийн сайдын тушаалаар батлагдсан боловч санхүүжилт төсөвт суухгүй байгаатай шууд холбоотой байна. Манай улсын гахайн аж ахуй эрхлэн үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгж болох “Зургаан хошуу” ХХК нь 1998 оноос эхлэн гахайн аж ахуй эрхлэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2018 онд өөрийн гахайг төлөвлөгөөтэйгөөр нядалгаанд оруулан дуусгаж, Дани улсын мэргэжилтнүүдийн хяналттай гахайн фермерээ шинэчлэн ОУ-ын стандартын дагуу засвар үйлчилгээ, ариутгалыг 1.5 тэрбум төгрөгөөр хийсэн. Одоо үржлийн цөм сүргийн гахайг Дани улсаас оруулж ирэх гэрээ хэлцэл хийж, санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэх талаар ажиллаж байна. Дани улсын гахай нь дэлхийд №1, үржлийн ажил нь сайн өвчингүй гэдгээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн. Бүх улс орон Дани улсаас үржлийн гахай авч байгаа болно. Бодлогын түвшинд Европын бүсээс цэвэр үүлдрийн үржлийн гахайг импортлох бүх нөхцөл бүрдсэн боловч санхүүжилт бүрдэхгүй байна.</p>	
3.5. Өндөр ашиг шимт, баталгаажсан зөгийн үүлдрийн 2000 бүлийг импортлон нутагшуулах, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, зөгийн үржлийн ажлыг сайжруулах, чадавхижуулах арга хэмжээг мэргэжлийн байгуулага, холбоодтой хамтран хэрэгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын дэмжлэгээр зөгийн аж ахуйн кластерыг хөгжүүлэх;						
30	3.5.3. Зөгийн аж ахуйг чадавхижуулах, кластерын систем хөгжүүлэх арга хэмжээг гадаадын хөрөнгө оруулалтын дэмжлэгээр хэрэгжүүлнэ.	2019-2023			<p>Зөгийн аж ахуйн Мон Апи кластер нь жилдээ 150-180 тонн зөгийн бал хураан авах хүчин чадал бүхий Монгол улсын анхны кластерыг байгууллаа. Тус кластерын үндсэн зорилго нь зөгийн аж ахуй эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлснээр тэдэнд өрхийн үйлдвэрлэлээс арилжааны шинжтэй бизнесийг эрхлэхэд дэмжлэг үзүүлж зөгийн салбар дахь бизнесийн төрлийг олшруулах, өргөжүүлэх, зөгийн бүтээгдэхүүний борлуулалтын боломжуудыг бий болгосноор тэдний ашиг орлогыг нэмэгдүүлэхэд оршино. Монгол улсын 10 аймгийн 17 суманд байрших 38 зөгийн аж ахуйг хамрагдсан бөгөөд Өвөрхангай 1, Булган 3 Дархан уул 11, Дорнод 2, Орхон 3, Төв 4, Сэлэнгэ 8 Хөвсгөл 1, Хэнтий, УБ-2 зөгийн аж ахуй эрхэлж</p>	100%

					байна. Зөгийн аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд зөгийчдийн мэдлэгийг дээшлүүлж, гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжүүлэх хүрээнд Монголын талаас 6 хүний бүрэлдэхүүнтэй баг Канад улсын Монреал хотод зохион байгуулсан “APIMONDIA-46” их хуралд 2019 оны 9 дүгээр сарын 8-наас 09-р сарын 12-ны өдөр оролцож, үзэж сонирхсон мэдсэн туршлагаараа зөгийчдөд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч байна. 2019 онд ЖДҮХС-гаас зөгийн 1 аж ахуйд 281 сая төгрөгийн зээл олгов. Азийн хөгжлийн банкны туслалцааны хүрээнд хэрэгжиж буй “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” төслийн хүрээнд 5-аймгийн 40 аж ахуйн нэгжид 1548 зөгийн гэр, 268 зөгийн сэмж буцалтгүйгээр олголоо. Үүний зр дүнд зөгийн аж ахуйн тогтвортой өсөлт бий болж, авах балны хэмжээ нэмэгдэж, аж ахуйн орлогын түвшин нэмэгдэж байна.	
3.6. Хот, суурингийн хүн амын хүнсний хэрэгцээнд эрчимжсэн аж ахуйгаас бэлтгэн нийлүүлэх сүү, мах, өндөг, зөгийн бал болон бусад түүхий эд, бүтээгдэхүүний хангамж, хүртээмж, аюулгүй байдлын баталгааг сайжруулах үйл ажиллагаанд бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх.						
31	3.6.2. Цэцэрлэг, бага ангийн хоол, үдийн цайнд үнээний эрүүл, цэвэр сүү боловсруулж үйлдвэрлэсэн сүү, тараг өдөр бүр уулгах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх	2019-2023			“Үдийн цай” хөтөлбөрийн санхүүжилт БСШУСЯ-ны төсөвт тусгагддаг. Үндсэн байгууллагаар БСШУСЯ байх өөрчлөлтийг төлөвлөгөөнд оруулах санал 2 удаа өгсөн. “Дэлхийн сүүний өдөр”-ийг ХХААХҮЯ, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, дотоодын сүү боловсруулах үйлдвэрүүд хамтран “Эх орны сүү-Эрүүл хүнс” уриан дор 2019 оны 6 дугаар сарын 01-ний өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулж, 10000 хүүхдэд сүү, сүүн бүтээгдэхүүн бэлэглэж, сүүний хэрэглээг нэмэгдүүлэх ач холбогдлын талаар сурталчлав. Мах, сүүний анхдугаар аяны хүрээнд сүү боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран нийслэлийн ЕБ-ийн 143, 93, 17, 3, 14-р сургуулиудын бага ангийн хүүхдэд өдөр бүр сүү, сүүн бүтээгдэхүүн өгөх нийгмийн хариуцлагатай ажлыг сүү боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран зохион байгуулсан. ЕБС-ийн 800 гаруй хүүхэд хамрагдсан. ЕБС-ийн бага ангийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрийн нэр төрөлд сүү боловсруулах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг оруулах тухай 2019 оны 01/4732 тоот албан бичиг БСШУСЯ-нд хүргүүлсэн. Дэлхийн сурагчдын сүүний өдрийг тохиолдуулан 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Сэлэнгэ аймгийн ЕБС-ийн 5000, Ховд аймгийн ЕБС-ийн 5000 гаруй хүүхдэд сүү, сүүн бүтээгдэхүүн бэлэглэж, сүүний хэрэглээний ач холбогдлын талаар сурталчилсан байна.	70%
3.7. Эрчимжсэн аж ахуй, тариалангийн үйлдвэрлэлийг хослон эрхлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, гурилын үйлдвэрүүдийг түшиглэн бүс нутгийн хэмжээний тэжээл үйлдвэрлэл, тэжээл хүргэлтийн үйлчилгээний ложистикийг хөгжүүлэх.						

32	3.7.1. Эрчимжсэн аж ахуй, тариалангийн үйлдвэрлэл хослон эрхлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.	2019-2023		<p>Эрчимжсэн мал аж ахуйн тэжээл үйлдвэрлэлийн үйлдвэрүүд нийт 193.6 мянган тн тэжээл үйлдвэрлэх боломжтой ч хүчин чадлынхаа 26.6 хувийг ашиглан тэжээл үйлдвэрлэж байгаа нь ихэнх үйлдвэрүүд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхгүйн зэрэгцээ тэжээлийн түүхий эдийн олдоц муу байгаатай холбоотой. 2017-2019 онд Баян-Өлгий аймгийн Өлгий суманд цагт 2 тн хорголжин тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай, Булган аймгийн Хангал суманд цагт 0.1 тн, Өвөрхангай аймгийн Хужирт суманд цагт 0.6 тн, Төв аймгийн Лүн суманд цагт 5 тн багсармал тэжээл, Сэлэнгэ аймгийн Баянгол суманд цагт 4 тн холимог тэжээл, УБ хотын Сонгино хайрхан дүүрэгт протеон тэжээлийн үйлдвэр тус тус ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж байна. Манай улсад нутагшсан бургалтай сортын царгасын үр үржүүлдэг “Хүүлэй хааны хишиг” ХХК 1000 га-д царгас тариалж, Булган, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 100 га-д царгас тариалах, үр үржүүлэх ажилд дэмжлэг үзүүлж тэжээл үйлдвэрлэлийг 2018 онд 1200 тн ногоон тэжээлээр нэмэгдүүлсэн. Мөн царгасын үр үржүүлгийг 720 га талбай, хөх тарианы үр үржүүлгийг 200 га талбайгаар нэмэгдүүлж малын тэжээл тариалалтыг 0.05 хувиар өсгөсөн. Уурагт таримал тэжээл тариалах төслийн хүрээнд 58.8 сая төгрөгийн зээлийг Мал хамгаалах сангаар дамжуулан авч Баян-Өлгий аймагт "Өлгий агро" ХХК цагт 1-2 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай хорголжин, багсармал тэжээлийн үйлдвэр байгуулсан. Баян-Өлгий аймгийн тэжээлийн хэрэгцээ 10-15 мянган тонн бөгөөд тухайн үйлдвэр 2018 онд 100 га талбайд улаан буудай, арвай, овьёос, царгас, эрдэнэ шиш, олон наст, судан өвс зэрэг малын тэжээлийн ургамлыг усалгаатай нөхцөлд тариалан, тэжээл үйлдвэрлэж аймгийн тэжээлийн хэрэгцээний 6%-ийг хангаж байна. Хүчин чадлаараа ажиллавал аймгийн жилийн хэрэгцээний 50 хувийг дангаараа хангах боломжтой болсон.</p>	70%
3.8. Одоо байгаа малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо, байршил, хүчин чадлын ашиглалтын түвшинг тогтоож, тэжээлийн үндсэн түүхий эдийн нөөцийг бүрдүүлэхэд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, эрчимжсэн аж ахуйн хүчит тэжээлийн хангамжийг 30 хувиар сайжруулах.					
33	3.8.1. Малын тэжээлийн үйлдвэр, цехийн тоо, байршил, хүчин чадлын ашиглалтын түвшинг тогтооно	2019		<p>Малын тэжээл үйлдвэрлэдэг нийт 30 аж ахуйн нэгж, цехүүд байна. Үүнээс томоохон 6 аж ахуйн нэгж байгаагаас Улаанбаатар хотод 4, Сэлэнгэ аймагт 1, Дорнод аймагт 1 байна. Дээрх үйлдвэрээс байнгын үйл ажиллагаа явуулдаг 22, улирлын чанартай 8 үйлдвэр, цех байгаа ба тэдгээрийн нийлбэр хүчин чадал нь жилд 193.6 мянган тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд нийт хүчин чадлынхаа 26.6%-д малын тэжээл үйлдвэрлэж байна. Эрчимжсэн аж ахуйн тэжээлийн үйлдвэрлэл</p>	100%

					нэмэгдүүлэх зорилгоор "Уурагт таримал тэжээл тариалж тэжээлийн нөөц нэмэгдүүлэх" төсөл зарлан 17 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, 1.0 тэрбум төгрөгийн зээл олгосноор 2018 онд тэжээлийн ургамал тариалалт 1000 га-гаар нэмэгдсэн. Манай улсад нутагшсан бургалтай сортын царгасын үр үржүүлдэг "Хүүлэй хааны хишиг" ХХК-тай хамтран байгалийн эрсдэлд өртөмтгий аймгуудад уурагт таримал тэжээл тариалах ажлыг эхлүүлж Булган, Сэлэнгэ, Төв аймагт тус бүр 100 га-д царгас тариалав. Мөн царгасын үр үржүүлэх 720 га талбай, хөх тарианы үр үржүүлэх 200 га талбайг нэмэгдүүлж малын тэжээл тариалалтыг 0.05 хувиар өсгөсөн байна.	
34	3.8.2. Эрчимжсэн аж ахуйн тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хүргэлтийн үйлчилгээг сайжруулна	2019-2023			2019-2020 оны өвөлжилт, хаваржилтад шаардлагатай тэжээлийн хэрэгцээг дотоодын үйлдвэрийн хүчин чадлыг ашиглан үйлдвэрлэх зорилгоор хивэгний экспортыг 2020 оны 4 сарын 01-ний өдөр хүртэл хязгаарласан байгаа. Үүнтэй холбогдуулан гурилын үйлдвэрүүдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, үйлдвэрийн өөрсдийн агуулахад хадгалагдаж байгаа тэжээлийг худалдан борлуулах чиглэлээр санал солилцож, 22 аймаг, нийслэлээс тэжээлийн хэрэгцээний талаарх судалгаа авч Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгино хайрхан дүүрэгт тэжээлийн тусгай цэг ажиллуулж, мөн орон нутагт түүхий эдийн зах дээр малын тэжээл худалдаалах цэг гаргуулан аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллаж, тэжээлийн хүргэлтийн үйлчилгээг сайжруулсан нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн ажил болж байна. Үүний үр дүнд тухайн орон нутагт дутагдаж байсан тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж, малчид, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг зах зээлд ойртуулж, зардлыг бууруулав.	70%
3.9. Тариалангийн 100,0 мянга хүртэлх га талбайд тэжээлийн ургамал тариалж, эрчимжсэн аж ахуйн шүүст болон ногоон тэжээлийн хангамжийг 50 хувиар нэмэгдүүлэх.						
35	3.9.1. Малын тэжээлийн ургамал тариалах талбайг эргэлтэнд оруулна.	2019-2023			Малын тэжээлийн ургамал тариалах талбайг эргэлтэд оруулах зорилгоор Аймаг дундын отрын бүс нутаг дахь тэжээлийн нөөцийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 340 га талбайг тариалалт хийхэд бэлтгэж, 2018 онд 80 га талбайд тэжээлийн ургамал тариалсан бол 2019 онд 120 га талбайд тариалж, өмнөх оноос 80 га талбай буюу 50%-иар нэмэгдүүлсэн. Улсын хэмжээнд 2019 онд тэжээлийн ургамал тариалалт 45.7 мянган га талбайд хүрсэн нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлтээс 15.0 мянган га талбай буюу 32.8%-иар нэмэгдсэн байна.	70%

36	3.9.2. Эрчимжсэн аж ахуйн шүүст болон ногоон тэжээлийн хангамжийг эрс нэмэгдүүлнэ	2019-2023		<p>Эрчимжсэн аж ахуйн шүүст болон ногоон тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Борнуур суманд 30 га талбайд холимог ногоон тэжээл, 5 га талбайд царгас, Сүмбэр суманд 30 га талбайд холимог ногоон тэжээл, 5 га талбайд царгас тариалах ажлыг зохион байгуулав. Энэ үйл ажиллагааг “Тайшир өргөө” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний хүрээнд 2 сумын бэлчээр ашиглагчдын хэсгийн малчдын нийт 60 га талбайд тариалах холимог ногоон тэжээл /хошуу будаа+гурвалжин будаа+арвай+вандуй/, 10 га талбайд тариалах олон наст тэжээлийн ургамал болох царгасын сайн чанарын үрээр хангаж, дээрх компанийн сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийн тусламжтай үрийн нормыг тооцоолон тариалалтыг хийв. Сүмбэр сум 30 га холимог ногоон тэжээл тариалсан талбайгаас нийт 28 тн тэжээл (0.6 ц/га) хураан авч, 10 тн дарш бэлтгэж, 18 тн-ийг БАХ-ийн малчдад хуваарилан олгосон. 2018 онд хураан авсан ногоон тэжээлээс үлдсэн 731 боодлыг аймгийн фондод хүлээлгэн өгч, 330 боодлыг жил хадгалсан учир сумын тэжээлийн үйлдвэрт өгсөн. Борнуур сумын 4 хэсэг нийт 30 га талбайд тариалалт хийж, нийт 84.6 тн ногоон тэжээл хураан авсан. Мөн улсын хэмжээнд 2019 онд 124,0 мянга тн ногоон тэжээл хураан авч өмнөх оныхоос 30.0 мянган тн-оор нэмэгдсэн.</p>	70%
4.3. Эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг багасгах, хадлан, тэжээлийн өртгийг бууруулах хүчин зүйлсийг судлан тогтоож, мал, амьтны төрөл тус бүрт зориулагдсан тэжээллэгийн үр ашигтай хувилбаруудыг туршилтаар гаргахад бодлогын дэмжлэг үзүүлэх;					
37	4.3.2. Эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг багасгах хүчин зүйлсийг судалгааг хийнэ.	2019-2020		<p>ЗГ-ын 2014 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 5, 24, 25, 26 дахь заалтад заасны дагуу “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлд нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, дүн шинжилгээг хийсэн. “ЭМАА-н хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрөөр шийдвэрлэхээр тусгаж байгаа зорилт нь захиргааны үйл ажиллагаанд тодорхой сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй. Учир нь тус хөтөлбөр хэрэгжсэнээр ямар нэгэн зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт орохгүй, зорилтот бүлгийн хүмүүст хариуцлага, чиг үүргийн хуваарилалт хийхгүй юм. УИХ-ын 2016 онд баталсан Тариалангийн тухай хуульд тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн заагийг тогтоох асуудлыг ЗГ шийдвэрлэхээр заасны дагуу уг арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээг сум, аймгийн ИТХ-ын шийдвэр, саналыг үндэслэн ЗГ-ын тогтоолоор</p>	70%

					шийдвэр гарна. Гэхдээ энэ нь ЭМАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хөндөхгүй. Иймд уг бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилт, үйл ажиллагааны арга хэмжээ нь зорилтот бүлгийн эрх ашгийг дээдлэх, үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх боломжийг нээж өгч байгаа болно. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг ЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 400 дугаар тогтоолоор батлуулсан. Энэ хөтөлбөрийн 4.4.3-т Эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг багасгах, хадлан тэжээлийн өртгийг бууруулах хүчин зүйлсийг судлан тогтоох талаарх судалгааг үргэлжлүүлэн хийж байгаа болно.	
38	4.3.3. Мал, амьтны төрөл тус бүрт зориулагдсан тэжээллэгийн туршилтууд хийнэ	2019-2021			Мал, амьтны төрөл тус бүрд зориулагдсан тэжээллэгийн туршилтыг Бүгд найрамдах Солонгос улсын Копиа-Монгол байгууллага Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран хэрэгжүүлж буй Өвлийн улиралд махны чиглэлийн өсвөр бордох төслийн хүрээнд махны чиглэлийн өсвөр үхэр бордоход орон нутгийн олдоц ихтэй түүхий эдийг оролцуулсан 6 төрлийн тэжээлийн жор зохиож, боловсруулан өвлийн улиралд 2 аж ахуйн нэгжийн 44 өсвөр үхэрт туршсан. Туршилтын дүнгээр үхрийн амьдын жин өдөрт 800-1000 гр-аар нэмэгдэж байсан нь үр дүнтэй ажил болсон байна. Мөн Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилттэй хэрэгжиж байгаа Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төслийн хүрээнд зөгийн шинэ төрлийн тэжээл бий болгох туршилт хийж элсэн чихэр, хөрөнгө, шар буурцаг, тэжээлийн нэмэлт оролцсон тэжээлийн жорыг сонгож зөгийн уурагт тэжээл хийсэн. Уурагт тэжээлийг аж ахуй нэгжийн захиалгын дагуу ХААИС-ийн МААБТС-ийн тэжээл үйлдвэрлэлийн цехэд үйлдвэрлэж иргэн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж байна. Уурагт тэжээлийг хэрэглэснээр зөгийн бүлийн хүч нэмэгдэж, бал хураалт эрчимтэй нэмэгдэж байна.	70%
4.4. Дарш хийх, олон найрлагат хорголжин, багсармал тэжээл, макро, микро элементээр баяжуулсан эрдсийн шахмал, уурагжуулсан, витаминжүүлсэн тэжээл үйлдвэрлэлд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, мал, амьтны төрөл, ашиг шимийн чиглэл, түвшин, физиологийн онцлогт нийцсэн төгс чанартай тэжээлээр хангах нөхцөл бүрдүүлэх;						
39	4.4.1. Эрчимжсэн мал аж ахуйн мал, амьтны төрөл, ашиг шимийн чиглэл, түвшин, физиологийн онцлогт нийцсэн төгс чанартай тэжээлээр хангах нөхцөл бүрдүүлнэ.	2019-2023			Махны чиглэлийн өсвөр үхэр бордоход орон нутгийн олдоц ихтэй газар тариалангийн хаягдал түүхий эдийг оролцуулсан тэжээлийн шинэ жор зохиож, туршилт үр дүнтэй ажил болсон нь улсын хэмжээнд ашиглаж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой болоод байна. Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилттэй хэрэгжиж байгаа Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил төслийн хүрээнд зөгийн шинэ төрлийн тэжээл бий болгох туршилт хийж элсэн чихэр,	40%

					хөрөнгө, шар буурцаг, тэжээлийн нэмэлт оролцсон тэжээлийн жорыг сонгож зөгийн уурагт тэжээл хийсэн. Уурагт тэжээлийг аж ахуй нэгжийн захиалгын дагуу ХААИС-ийн МААБТС-ийн тэжээл үйлдвэрлэлийн цехэд үйлдвэрлэж иргэн, аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж байна. Уурагт тэжээлийг хэрэглэснээр зөгийн бүлийн хүч нэмэгдэж, бал хураалт эрчимтэй нэмэгдэж байна. Махны чиглэлийн үхэр, зөгийн физиологийн онцлогт нийцсэн төгс чанартай тэжээлээр хангах суурь нь тавигдав.	
4.5. Мах, махан бүтээгдэхүүн, өндөгний техникийн зохицуулалтыг боловсруулах, гахай, шувууны мах, өөхний стандартыг тогтоох, шинэчилэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;						
40	4.5.1. Мах, махан бүтээгдэхүүн, өндөгний техникийн зохицуулалтыг боловсруулж, батлуулан хэрэгжүүлнэ	2019-2021			Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль мөрдөгдөж байгаатай холбогдуулан тус хууль тогтоомжид нийцүүлэн “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын төслийг шинэчлэн боловсруулсан. Тус зохицуулалтын төслийг эцэслэх, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж батлуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	70%
4.6. Эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бүс нутагт олон улсын жишигт нийцэхүйц үржил селекцийн чиглэлийн аж ахуй, явуулын үйлчилгээг бий болгох, үржүүлэг, технологийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадавхийг сайжруулах;						
41	4.6.1. Олон улсын жишигт нийцэхүйц үржил селекцийн чиглэлийн аж ахуй, явуулын үйлчилгээг бий болгоно	2019-2023			Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р баг Буурлын энгэр хэмээх газарт Олон улсын жишигт нийцсэн малын үржил селекцийн чиглэлийн тоног төхөөрөмж бүхий Малын удмын сангийн үндэсний төвийн цогцолбор 2018 оноос ашиглалтад орж, үйл ажиллагаа хэвийн явуулж байна. 2020 онд орон нутгийн мал үржүүлгийн техникч нарын хэрэгцээнд захиалгын дагуу үр, азотоор явуулын үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Зохиомол хээлтүүлгийн 11 техникч нартай гэрээ байгуулан УБ хот, Төв, Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул аймгийн иргэн, аж ахуй нэгжд зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ үзүүлэв. Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой сумдад ХАА-н тасаг байгуулагдсан, Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлагаас хэрэгжүүлж буй “Ногоон алт” төсөлтэй хамтран Төв аймгийн Борнуур, Сүмбэр суманд ажиллах зохиомол хээлтүүлгийн техникчийг сургаж бэлтгэн тус бүр 4.0 сая төгрөгийн зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгслээр хангав.	100%
42	4.6.2. Нийслэлийн үхэр сүрэгт ангилан ялгалт хийж үхрийн үүлдэр бүрээр нарийвчлан бүртгэлжүүлсэн тооллогыг жил бүр хийнэ	2019-2024			Нийслэлийн мал бүхий зарим дүүргийн үржлийн бухад 2019 онд үзлэг ангилалт хийв. Ангилал-тад Хан-Уул дүүргийн хэмжээнд нийт 75 бух хамрагдсанаас 12 бух үржилд тэнцэж, 63 бух үржилд тэнцээгүй бөгөөд эдгээр хээлтүүлэгч нь гарал үүсэл тодорхой бус, галбирын	70%

					согогтой, сүүний үхрийн хэвшлээ алдсан зэрэг үндсэн дутагдалтай байна. Сонгино хайрхан дүүргийн нийт 146 бух хамрагдсанаас 78 бух үржилд тэнцэж, 68 бух үржлийн шаардлага хангаагүй байна. Үржилд тэнцэхгүй хээлтүүлэгчийг заазлах, үнээнд зохиомол хээлтүүлэг хийлгэх талаар иргэн, аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. Зохиомол хээлтүүлгийн 11 техникчтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, УБ хот, Төв, Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул аймгийн иргэн, аж ахуй нэгжийн үхэрт зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ үзүүлж, иргэн, аж ахуйн нэгжийн нийт 2725 үнээг зохиомлоор хээлтүүлэв. Мал сүргийн мэдээллийн онлайн системийг бүрдүүлэх ажлын хүрээнд 2019 онд ХХААХҮ-ийн сайдын А-163 дугаар тушаалаар улсын төсвийн 55.6 сая төгрөгийн санхүүжилтээр үржилд ашиглаж буй хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч малыг ялган тэмдэглэх, малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг 7 аймгийн 58 сум, нийслэлийн мал бүхий 3 дүүргийн нийт 95.9 мянган толгой малд гүйцэтгэхээр ХХААГ-тай гэрээ байгуулж, 10.2 мянган бух, 28.2 мянган хуц, 17.2 мянган ухна, 8.1 мянган үнээ, 23.0 мянган эм хонь, 9.0 мянган эм ямаа, нийт 95.9 мянган малыг ялган тэмдэглэж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж байна.	
43	4.6.5. Малын үржил селекцийн аж ахуйн явуулын үйлчилгээг шинээр бий болгох	2019-2021		Захиалгын дагуу Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд болон Улаанбаатар хот орчмын иргэн аж ахуйн нэгжийн малд зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг технологийн дагуу тасралтгүй хангаж ажиллав. Мал үржүүлгийн техникчдийг багаж тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн ХХААГазарт бод, бог малын зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж, хэрэгслийг улсын төсвийн хөрөнгөөр олгов.	70%	
44	4.6.6. Малын нөхөн үржүүлгийн техникч бэлтгэх сургалтыг бод, бог малын төрлөөр явуулах	2019-2021		ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуультай хамтран: -2018-2019 оны хичээлийн жилд тусгай дунд мэргэжлийн мал зүйчид бакалаврын боловсрол олгох 1,5 жилийн сургалтад 11 мал зүйч хамрагдаж диплом гардаг авсан. 2019-2020 оны хичээлийн жилд эчнээ 2,5 жилийн сургалтад 18 мал зүйч мэргэжилтэн тус тус хамруулсан. “Бог малын ангилагч, шинжээч бэлтгэх” сургалтаар 13 аймаг, нийслэлийн 37 мал зүйчид ангилагч, шинжээч мэргэжлийн үнэмлэх олгов. 2. МУСҮТөв, Нутаг академи ТББ-тай хамтран мал үржүүлгийн техникч бэлтгэх вакуум сургалтыг 6 аймагт	70%	

					зохион байгуулж, 9 мэргэжилтэнд "Мал үржүүлгийн техникч" мэргэжлийн үнэмлэх олгов.	
45	4.6.7. Малд зохиомол хээлтүүлэг хийхэд шаардагдах багаж хэрэгсэл, шингэн азотоор хангах, бэлтгэн нийлүүлэх үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ.	2019-2023			Үндэсний генийн сангийн хэрэгцээнд сардаа 150-200 литр, жилийн хэрэгцээнд нийт 2280 литр, үр үйлдвэрлэл, үржүүлгийн техникч нарт 200 литр нийт 2480 литр азот үйлдвэрлэн үйлчилгээнд ашиглав. Аймаг, нийслэлийн 12 мал үржүүлгийн техникч нартай гэрээ байгуулан ажлыг дүгнэн ажиллаж байна. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, гэрээт техникч нарын захиалгын дагуу үр, азотоор 100 хувь хангаж хамтран ажиллав.	100%
46	4.6.8. Малын үржүүлэг, технологийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чадавхийг сайжруулна.	2019-2023			Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор орон нутгийн мэргэжлийн байгууллагад дэмжлэг үзүүлж, 21 аймаг, нийслэлийн ХХААГазарт 7 нэр төрлийн багаж хэрэгслээр хангав. /палкметр, лентметр, циркульметр, бог малын пүү, бог, бод малд зохиомол хээлтүүлэг хийх иж бүрдэл, гүн хөлдөөсөн үр хадгалах зориулалттай дьюар сав/	70%
4.8. Өндөр ашиг шимт малын үр, хөврөлийг малын генийн санд хадгалах, гүн хөлдөөсөн болон хүйс жолоодсон үрийг ашигласан зохиомол хээлтүүлгийн ажлын цар хүрээг тэлэх, хөврөл үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах биотехнологийн ололтыг нэвтрүүлэх арга хэмжээг дэмжих;						
47	4.8.1. Өндөр ашиг шимт малын үр, хөврөлийг малын генийн санд хадгалах арга хэмжээг хэрэгжүүлнэ	2019-2023			АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд 14000 тун үрийг импортлон МУСҮТ-ийн генийн санд баяжуулалт хийв. Монгол малын үндэсний генийн санг импортын гүн хөлдөөсөн үрээр баяжуулах зорилгоор Бүгд Найрамдах Франц улсаас импортлон үржүүлж буй өндөр ашиг шимт Эдельбай, Меринос, Брешион дучер, Романов зэрэг 4 үүлдрийн 6 хуцаас эрүүл ахуй стандартын шаардлага хангасан 4390 тун үр, сарлагийн бухаас 260 тун үр, нийт 4650 тун үрийг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан орчинд, технологийн дагуу авч үндэсний генийн санд дотоодын үрээр мөн баяжуулалт хийсэн.	70%
48	4.8.2. Зохиомол хээлтүүлгийн ажлын цар хүрээг тэлэх	2019-2023			Аймаг, нийслэлийн 12 мал үржүүлгийн техникч нартай гэрээ байгуулан ажлыг дүгнэн хамтран ажиллаж байна. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, гэрээт техникч нарын захиалгын дагуу сүү, махны мах-сүүний хосолмол ашиг шимт чиглэлийн бухын 1455 тун үр, сүүний үхрийн 305 тун үр, махны үхрийн 915 тун үр, Эдельбай хуцын 50 тун үр, нийт 2725 тун гүн хөлдөөсөн үрийг малын үндэсний генийн сангаас нийлүүлэн ханган ажиллаж байна. Аймаг, нийслэл, сум дүүргийн МАА-н дарга мэргэжилтнүүдийн захиалгын дагуу, 2018 оны 09 дугаар сараас 01-нээс	100%

					2019 оны 12 сарын 01 хүртэлх хугацаанд бод 2008 толгой, бог 722 толгой нийт 2722 толгой малд зохиомол хээлтүүлэг хийв. Гэрээт үржүүлгийн техникч нарт цаг хугацаанд нь үр азотоор ханган ажиллаж Улаанбаатар хот орчмын 1560 үнээнд өндөр ашиг шимт бухын хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийв. Дархан-Уул аймгийн малчин Амаржаргалын суурьт Малын удмын сангийн үндэсний төвд хадгалагдаж байгаа Дархад омгийн хуцын үрээр зохиомол хээлтүүлэг хийв. “Нутаг түншлэл” ТББ-тай хамтран Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд Дэлгэрэхийн удаан омгийн ухнаас үр авч шингэлэн 538 ямаанд, Баянхонгор аймгийн Шинэжинст суманд Заслаа Жинстийн цагаан ямааны ухнаас үр авч шингэлэн 422 ямаанд тус тус зохиомол хээлтүүлэг хийв. Гэрээт зохиомол хээлтүүлгийн техникч нарын дунд ажил, мэргэжлийн уралдаан зарлан, уралдаанд шалгарсан Гэндэндарам, Наранбаатар, Дорждэрэм нарыг шагнаж урамшуулав.	
49	4.8.3. Хүйс жолоодсон үр, хөврөл үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах биотехнологийн ололтыг нэвтрүүлэх арга хэмжээг дэмжинэ.	2019-2023		2019 онд импортолсон хүйс жолоодсон үрээр Төв аймгийн Баянчандмань сумын нэг фермерийн аж ахуйд зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлэв. Үүнд: сүүний үхрийн Хар тарлан, Алату үүлдрийн 15 толгой үнээнд хүйс жолоодсон гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийв. Мөн Малын удмын сангийн үндэсний төв нь иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага, гэрээт техникч нарын захиалгын дагуу мах-сүүний чиглэлийн хосолмол ашиг шимт болон сүү, махны үхэр, хонины нийт 2725 тун гүн хөлдөөсөн үрээр Нийслэл, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгууд болон Улаанбаатар хот орчмын малд зохиомол хээлтүүлэг хийж хамтран ажиллав.	100%	
4.10. Гахай, тахианы эрчимжсэн аж ахуйд ашиглагддаг малын эмийг улсын бүртгэлийн жагсаалтад оруулах, мал эмнэлгийн үйлчилгээний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын санхүүжилтийн ялгавартай байдлыг арилгах;						
50	4.10.2. БНХАУ-аас үржлийн гахай импортлох 1995 оны хэлэлцээрийг шинэчлэх асуудлыг судалж, талуудын шийдвэрийн тохиролцоонд хүрнэ.	2019-2023		Монгол Улсын Засгийн газар 2017 онд БНХАУ-аас үржлийн гахай импортлох тухай 1995 оны хэлэлцээрийг шинэчлэх асуудлыг БНХАУ-ын Засгийн газарт санал тавьж харилцан зөвшилцсөн. Үүний хүрээнд гахай оруулж ирэх талаар ажил өрнүүлж эхэлж байсан. Гэвч 2018 оны 12 дугаар сараас эхлэн Зүүн өмнөд Азийн орнуудад Африкаас гаралтай гахайн гоц халдварт мялзан өвчин дэлгэрч газар авсан тухай Дэлхийн мал эмнэлгийн байгууллага мэдээлсэн. Тиймээс манай улс БНХАУ-аас гахай импортлохгүй байх байр суурьтай байна. Энэ талаар мал эмнэлгийн асуудал эрхэлсэн төв байгууллага болон хорио цээрийн асуудал эрхэлсэн байгууллага	100%	

					судалгаа хийж, цаашид БНХАУ-аас үржлийн болон таваарын гахай импортлох шаардлагагүй гэсэн цаг үетэй уялдуулсан бодлого гарган ажиллаж байна.	
4.11. Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үзлэг, шинжилгээ хийх, зохиомол хээлтүүлэг явуулах, малд үзлэг, ангилалт хийхэд шаардагдах багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх;						
51	4.11.2. Малд зохиомол хээлтүүлэг явуулах, малд үзлэг, ангилалт хийхэд шаардагдах багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ.	2019-2023			Малд үзлэг, ангилалт хийхэд шаардагдах багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн албанд тус бүр 1 ширхэг бог, бодын зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгслийг улсын төсвийн санхүүжилтээр олгов. 2020 онд малд зохиомол хээлтүүлэг хийхэд шаардагдах багаж хэрэгсэл болон малын үндэсний генийн сангийн хэрэгцээнд 6 ширхэг гүн хөлдөөсөн үр хадгалах танк захиалан төсөвт тусгуулан ажиллаж байна.	70%
4.12. Гойд ашиг шимт үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдаа, эрчимжсэн мал аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, техник, технологийн үзэсгэлэнг улсын хэмжээнд тогтмол зохион байгуулах.						
52	4.12.1. Гойд ашиг шимт үржлийн малын үзэсгэлэн, худалдаа, техник, технологийн үзэсгэлэнг улсын хэмжээнд тогтмол зохион байгуулна	2019-2023			Гойд ашиг шимт үржлийн мал шалгаруулах, өндөр ашиг шимтэй мал, амьтныг олон нийтэд сурталчлан таниулах, уламжлалт мал аж ахуйг ирээдүй, хойч үедээ өвлүүлэн үлдээх, малчид, үйлдвэрлэгчийн хөдөлмөр бүтээлийг үнэлж урамшуулах, харилцан туршлага солилцох зорилго бүхий “Шилмэл мал-2019” арга хэмжээг 2019 оны 09 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Төв аймгийн Зуун мод хотноо зохион байгуулав. Гойд ашиг шимт малын үзэсгэлэн, дуудлага худалдаанд 19 аймаг, нийслэлийн 45 сум, 6 дүүргийн 506 толгой мал, 5 толгой молтогчин туулай, бөднө, цацагт хяруул зэрэг 14 толгой шувуу нийт 525 толгой мал, амьтан шалгаруулалтад бүртгүүлэв. Эдгээрээс 12 номинацад 44 толгой мал, амьтныг Монгол улсын шилмэл мал, амьтнаар шалгаруулж шагнаж урамшуулав. Мөн “Шилдэг оролцогч иргэн”-ээр 2, “Шилдэг оролцогч аймаг”-аар 2, “Шилдэг оролцогч аж ахуйн нэгж”-ээр 2, “Шилдэг түнш байгууллага”-аар 2 аж ахуйн нэгжийг тус тус шалгаруулж, урамшуулав. Үржлийн малын үнэ хаялцуулах дуудлага худалдаанд нийт 45 толгой мал оролцуулан 3 толгой малыг худалдаалан 10.0 сая төгрөгийн борлуулалт хийлээ. Гойд ашигт үржлийн хонь, ямаа 312 толгой, үхэр 8 толгой нийт 320 толгой мал худалдаалагдаж зөвшөөрөгдсөн бүсэд сайжруулагчаар нийлүүлэгдлээ.	70%
5.1. Мал, амьтны сүргийн нөхөн үйлдвэрлэлийг мөчлөгийн үр ашигтай системд шилжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг үе шаттай бууруулах;						
53	5.1.1. Мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйнуудын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөлт хийж, үйлдвэрлэлийн	2019-2023			Сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөлт хийж, үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг багасгаж, дотоодын шингэн сүүний үйлдвэрлэлийг өвлийн улиралд нэмэгдүүлэн импортын хэмжээг багасгаж, хүн амын өдөр тутмын	100%

	улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.				хэрэгцээг чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангах явдал гэж үзэж байна. Харин зуны улирал дахь шингэн сүүний борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлд сүү боловсруулах өндөр технологи нэвтрүүлэх, зээлийн дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлыг судалж үе шаттай хэрэгжүүлнэ. Төв суурин газрын хүн амыг үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнээр хангах ажлыг нийслэлийн хэмжээнд 140 орчим, Дархан-Уул аймагт 100 гаруй худалдааны цэгээр тус тус худалдах ажлыг зохион байгуулсан. Сүүний урамшууллын журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны А-122 дугаар тушаалаар байгуулж ажиллаа. Журмын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна. Нийслэлийн хүн амын махны хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээр мах бэлтгэсэн дотоодын үйлдвэрт хүүгийн хөнгөлөлт үзүүлж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах арга хэмжээг зохион байгуулсан. Арилжааны банкны шалгуурт тэнцсэн “Баатрууд Тэнгэр”, “Дархан мийт фүүдс”, “Сүхбаатар мах маркет” ХХК 4.0 мянган тн мах бэлтгэснийг нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс нийлүүлж, нийслэлийн 8 дүүргийн хүнсний 137 дэлгүүрээр дамжуулан үхрийн ястай мах 7200 төг/кг, хонины ястай мах 6000 төг/кг, ямааны ястай мах 5500 төг/кг үнээр худалдаалсан нь зах зээл дэх жижиглэнгийн үнээс 16-45 хувиар хямд байсан.	
5.2. Мал, амьтны төрөл, үүлдэрлэг байдал, ашиг шимийн гарцтай уялдуулан сүрэгт явуулах үржүүлгийн хөтөлбөрийг шинэчилж, сүргийн хээлтүүлэг, төллөлтийг технологийн дагуу удирдаж, аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;						
54	5.2.1. Эрчимжсэн аж ахуйн сүрэгт явуулах үржүүлгийн хөтөлбөр, хээлтүүлэг, төллөлтийн графикийг шинэчилж, аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ	2019-2023			“Үржлийн малд хянан магадалгаа хийх, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих” журмын дагуу ХХААХҮ-ийн Сайдын тушаалаар үүлдэр омгоор баталгаажсан нөхцөлд тухайн малын үржил селекцийн ажлын 5-10 жилийн хөтөлбөрийг баталж, энэхүү хөтөлбөр, төлөвлөгөөнд хээлтүүлэгчийг үржүүлэг технологийн нэгжийн мэдэлд төвлөрүүлж бүс нутагтаа сайжруулагчаар ашиглах, цөм сүргийн малын тоо толгойг нэмэгдүүлэх асуудлыг тусган ажиллаж байна.	40%
55	5.2.2. Эрчимжсэн аж ахуйд мал сүргийн бүтцийн зохистой харьцааг	2019-2023			Баталгаажсан үүлдэр омгийн малыг үржүүлэх стратеги төлөвлөгөөг баталсан бөгөөд энэхүү төлөвлөгөөнд тухайн төрөл, үүлдэр омгийн малыг	70%

	бий болгох замаар бэлчээрийн доройтлыг бууруулах судалгаа, арга хэмжээг хэрэгжүүлэх				үржүүлэх бүс нутгийн асуудал тусгагдсан болно. Эрчимжсэн МАА эрхлэх бүс нутгийг тогтоох судалгааны хүрээнд нарийн ноост “Хангай” үүлдрийн хонийг хээрийн бүсэд үржүүлж болох эсэх талаар судалгаа хийсэн бөгөөд энэ ажлын үр дүнд Хангай хонийг зөвхөн ойт хээрийн бүсэд үржүүлэх нь үр дүнтэй гэсэн дүгнэлт гараад байна. Малын генетик нөөцийн төлөв байдлын тайлангаар нийт мал сүрэгт цэвэр үүлдрийн монгол мал 85.7-99.9%, эрлийз мал – 0.04-14.3%, гадаадаас авсан малын тоо нийт мал сүргийн 0.001-0.02 хувийг эзэлж байна. Төлөв байдлын тайланг гаргаснаар мал сүргийг үржүүлэх бүс нутгийг нарийвчлан тогтоох боломжийг бүрдүүлэв. Тухайлбал: Адуун сүргийн ашиг шимийн чиглэл, тэдгээрийн тархцыг авч үзвэл, нийт адууны 17.8% баруун, 35.4% хангай, 22.2% төв, 23.5% нь зүүн бүсэд тус тус үржүүлж байна. Тэмээн сүргийн 52.0%, үхэр сүргийн 60.0% орчим нь төвийн бүсэд, сарлагийн 80.0%-ийг хангайн бүсэд үржүүлэх боломжтой байна. Хонин сүргийн 21.6% нь баруун, 37.5% нь хангайн, 22.5% нь төвийн, 17.7% зүүн бүс, ямаан сүргийн 26.9% нь баруун, 34.9% нь хангайн, 24.6% нь төвийн, 12.9% нь зүүн бүсэд үржүүлж байна.	
5.3. Зах зээлд бэлтгэн нийлүүлэх түүхий эд, бүтээгдэхүүний чанар, хүнсний сүлжээний аюулгүй байдлыг баталгаажуулах бүртгэлийн системийг мэргэжлийн байгууллага, холбоодын үйл ажиллагаанд суурилан кластер, цогцолбор тус бүрт хэрэгжүүлэх;						
56	5.3.1. Зах зээлд бэлтгэн нийлүүлэх түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах бүртгэлийн системийг эрчимжсэн аж ахуйнуудад нэвтрүүлнэ.	2019-2023			Төв суурин газрын хүн амыг үйлдвэрийн аргаар боловсруулсан махаар хангах ажлыг нийслэлийн хэмжээнд 140 орчим, Дархан-Уул аймагт 100 гаруй худалдааны цэгээр тус тус худалдах ажлыг зохион байгуулсан. Нийслэлийн хүн амын махны хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээр мах бэлтгэсэн дотоодын үйлдвэрт хүүгийн хөнгөлөлт үзүүлж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах арга хэмжээг зохион байгуулсан. Арилжааны банкны шалгуурт тэнцсэн “Баатрууд Тэнгэр”, “Дархан мийт фүүдс”, “Сүхбаатар мах маркет” ХХК-иуд 4.0 мянган тн мах бэлтгэснийг нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс нийлүүлж, нийслэлийн 8 дүүргийн хүнсний 137 дэлгүүрээр дамжуулан үхрийн ястай мах 7200 төг/кг, хонины ястай мах 6000 төг/кг, ямааны ястай мах 5500 төг/кг үнээр худалдаалсан нь зах зээл дэх жижиглэнгийн үнээс 16-45 хувиар хямд байсан.	40%
5.4. Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх мах, сүүний улирлын хамаарлыг бууруулах, хангамжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлын баталгааг хангах хөшүүргийг урамшууллын системээр дамжуулж бий болгох, төлөвшүүлэх.						

57	5.4.2. Боловсруулах үйлдвэрт нийлүүлэх махны улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ	2019-2023			Нийслэлийн хүн амын махны хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоолын хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээр мах бэлтгэсэн дотоодын үйлдвэрт хүүгийн хөнгөлөлт үзүүлж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах арга хэмжээг зохион байгуулсан. Арилжааны банкны шалгуурт тэнцсэн “Баатрууд Тэнгэр”, “Дархан мийт фүүдс”, “Сүхбаатар мах маркет” ХХК-иуд 4.0 мянган тн мах бэлтгэснийг нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс нийлүүлж, нийслэлийн 8 дүүргийн хүнсний 137 дэлгүүрээр дамжуулан үхрийн ястай мах 7200 төг/кг, хонины ястай мах 6000 төг/кг, ямааны ястай мах 5500 төг/кг үнээр худалдаалсан нь зах зээл дэх жижиглэнгийн үнээс 16-45 хувиар хямд байв. Махны борлуулалтын хувьд 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 4140.4 тн, үүнээс хонины мах 1937.9 тн, ямааны мах 1152.6 тн, үхрийн мах 1049.8 тн худалдаалсан байна.	100%
58	5.4.3. Махны чиглэлийн өсвөр үхрийг эрчимтэй бордох, худалдах бусад улс орны туршлагыг нутагшуулна.	2019-2023			Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд ЖДҮХС-аас 14 аймгийн 34 иргэн аж ахуйн нэгжид 5.9 тэрбум, махны чиглэлийн хонины 2 аж ахуйн нэгжид 217 сая төгрөгийн зээл тус тус олгосон. Үр дүнд нь махны чиглэлийн үхрийн үүлдрийн арвин ашиг шимт үхрийн тоо 2018 онд 23.8 мянга байсан бол 2019 онд 33.7 мянга болж 9.9 мянгаар буюу 40-н хувиар өсөхөөс гадна малын гаралтай түүхий эдийн үнэ ханшийн уналтаас хамгаалах, малчин өрхийн орлого, амьжиргааны баталгааг хангасан. Дархан -Уул аймаг 2019 онд ӨМӨЗО-ны Хөх хот болон 3 аймгийн сүү, махны фермерүүд болон сүүний үйлдвэр, тэжээлийн ургамал тариалалтын чиглэлээр туршлага судлах аяллыг зохион байгуулж, 150 гаруй малчид, фермерүүд оролцсон байна.	100%
6.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутагт газар тариалан, мал аж ахуйн хосолсон үйлдвэрлэл хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, ажлын байр шинээр бий болгох санал, санаачилгыг хөрөнгө оруулалтын болон татварын бодлогоор дэмжих;						
59	6.2.1. Газар тариалан, мал аж ахуйн хосолсон үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.	2019-2023			Дархан-Уул аймаг орон нутгийн төсөвт цэвэр үүлдрийн махны үхрийн аж ахуйн суурьшлын бүс байгуулахад шаардлагатай 500 сая төгрөгийг тусгаж Булган аймгаас Сэлэнгэ үүлдрийн 100 толгой хээлтэгч худалдан авч, үржүүлж байна. 2018 онд цэвэр, эрлийз сүүний үхэр 75.1 мянган толгой байсны 25 хувь буюу 18.8 мянган толгой цэвэр үүлдрийн сүүний үхэр байсан. 2019 онд сүүний үхэр 100.9 мянган толгой болж өссөн. Үүнээс цэвэр үүлдрийн үхэр 24.3 мянга болж, өмнөх оноос 5,5 мянган толгой буюу 29.3 хувиар өссөн байна. Монгол Улс, Беларусь улсын ЗГ	100%

				<p>хоорондын хөнгөлөлттэй урт хугацааны зээлээр 2019 онд сүүний чиглэлийн хар тарлан үүлдрийн 1300 толгой хээлтэй гунжийг импортлон газар тариалан, тэжээлийн аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг түшиглэн тус бүр 300 үнээний хэд хэдэн цогцолбор ферм байгуулах тухай гэрээ, хэлэлцээр хийж, санамж бичигт гарын үсэг зурсан. Азийн Хөгжлийн банкны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн нэмэлт санхүүжилт" төслийн хөрөнгөөр Швейцарь улсаас сүүний чиглэлийн "Голштейн" (Хар тарлан), "Симменталь", мах-сүүний чиглэлийн "Brown Swiss", "Original Brounvieh", "Ангус" Улаан, махны чиглэлийн "Лиммузин" үүлдрийн өндөр ашиг шимт хүйс жолоодсон 1200 тун охин үр, 12.8 мянган тун гүн хөлдөөсөн үр, нийт 14.0 мянган тун үрийг 620.2 сая төгрөгийн хөрөнгөөр худалдан авч Малын удмын сангийн үндэсний төвд хүлээлгэж өгч, нийслэл болон томоохон хот суурингийн ойролцоох цэвэр үүлдрийн үхэрт зохиомол хээлтүүлэг хийж эхлээд байна.</p>	
60	6.2.2. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд инновацийг нэвтрүүлж, бүтээмжийг дээшлүүлнэ.	2019-2023		<p>МАН-н шийдлүүдийг нэвтрүүлэх туршилтын загварт цөлөрхөг хээрийн бүс болох Дундговь аймгийн Луус сумын Суварга багийн Хар толгойд бэлчээрийн хонь, ямаа өсгөн үржүүлж буй 7 малчин өрх, ойт хээрийн бүсэд хамаарах Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Баян мод багийн Майхны аманд бэлчээрийн үхрийн аж ахуй эрхэлж буй 7 өрх, Төв аймгийн Батсүмбэр сумын Цогт-Өндөр багийн нутагт сүүний хагас эрчимжсэн үхрийн аж ахуй эрхэлж буй 7 фермер, өрхийг ХХААХҮЯ-ны санал болгосны дагуу сонгож туршилтын ажлуудыг эхлүүлсэн нь байна. Уур амьсгалын өөрчлөлтийн эрчийг сааруулахад хивэгч малаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах асуудал нэн чухал. Шингэц сайтай, уургийн агууламж өндөртэй, энерги ихтэй тэжээлээр хивэгч малыг тэжээж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх нь уур амьсгалд ухаалаг шийдлийн нэг тул төслийн туршилтад сонгогдох үндэслэл болсон гэж үзэх боломжтой. Мөн түүнчлэн байгаль цаг уурын 3 өөр бүсэд хамаарах 3 төрлийн хивэгч малыг үйлдвэрлэлийн ялгаатай 2 тогтолцоотой өсгөн үржүүлж буй 3 малчдын бүлэг, чанартай тэжээлийн нөөцөө өөрсдөө бүрдүүлэх боломжийг бүрдүүлэх томоохон хөрөнгө оруулалтыг төслөөс үзүүлсэн нь төслийн зорилтуудыг биелүүлэх боломжийг бүрдүүлж байна. Үндэсний үйлдвэрлэгч "Сан-Оргиу" ХХК-д хуванцрыг дахин боловсруулж үйлдвэрлэсэн олон жилийн эдэлгээ даах баталгаатай эко шонтой өргөст торон хашаа бүхий тэжээлийн</p>	40%

					ургамал тариалах 2 га талбайг малчдын бүлэг тус бүрд бэлтгэн өгсөн бөгөөд мөн түүнчлэн тус бүрд нарны эрчим хүчээр ажиллах 70 м гүний худгийг гидрогеологийн хайгуулын дүгнэлтээр гаргаж өгсөн байна.	
61	6.2.3. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2019-2023			Мал хамгаалах сангаас 2019 онд 1,5 тэрбум төгрөгийг МАА-н үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохоор зориулж төсөвлөсөн боловч Засгийн газрын 2019 оны 179 дүгээр тогтоолоор МХС-г ЖДҮХС-тай нэгтгэсэн. Иймд ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 04 дүгээр зөвлөмжөөр ЖДҮХС-гаас олгох нийт зээлийн 25-аас доошгүй хувийг “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зээл олгохоор тусгасан. ЖДҮХС-ийн захирлын 2019 оны А/77, А/81, А/117 дугаар тушаалуудаар Нийслэл хот болон томоохон хот суурингийн ойролцоо сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч 18 аймгийн 45 иргэн, аж ахуйн нэгжид 2.8 тэрбум, махны үхрийн аж ахуй эрхлэгч 14 аймгийн 34 иргэн, аж ахуйн нэгжид 5.9 тэрбум төгрөг, нийт 79 иргэн, аж ахуйд 8.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 5 жилийн хугацаатай бага хүүтэй олгосон.	100%
7.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид туршлага, мэдээллээ харилцан солилцох, судлах, технологийн болон эдийн засгийн мэдлэгээ сайжруулахад чиглэгдсэн олон талт сургалтыг зохион байгуулж, чадавхижуулах, мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлэх						
62	7.1.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд технологийн болон эдийн засгийн мэдлэгээ сайжруулахад чиглэгдсэн олон талт сургалтыг зохион байгуулж, мэдээллээр хангана.	2019-2023			Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд технологийн болон эдийн засгийн мэдлэгээ сайжруулахад чиглэгдсэн олон талт сургалт, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулав. Эрчимжсэн мал аж ахуйн төвийн бүсийн зөвлөгөөнийг Дархан-Уул аймагт, зүүн бүсийн уулзалт зөвлөгөөнийг Дорнод аймагт 2019 оны 4, 5 сард зохион байгуулав. Сүү-сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн чуулганыг нийслэлд 12 дугаар сард зохион байгуулж нийт 16 аймгийн 1100 орчим эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид оролцов. “Орчин үеийн өвс, тэжээл үйлдвэрлэлийн тогтолцоо бий болгох нь” сэдэвт БНХАУ-ын сургалтад аймаг, нийслэлийн бэлчээр тэжээл, усан хангамж хариуцсан 25 албан хаагчийг хамруулав. Канад улсад болсон “APIMONDIA 2019” дэлхийн зөгийчдийн холбооны 46-р чуулга уулзалтад оролцов. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНЭУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр ХХААХҮЯ-ны ТНБД-ын дарга Т.Жамбалцэрэн, тус улсын Мал аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн, загасны аж ахуйн яамны Нарийн бичгийн дарга Ш.А.Чатурвэди нар “Малын эрүүл мэнд, сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт хамтран ажиллах иж бүрэн ажлын төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан. Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөө хөрөнгө	100%

					оруулагчдын форумыг Улаанбаатар хотноо 2019 оны 10 сарын 29-ны өдөр зохион байгуулав.	
63	7.1.2. Эрчимжсэн мал аж ахуйн техник, технологи, ололтын үзэсгэлэнг 2 жилд тутамд нэг удаа зохион байгуулна.	2019-2023			Гойд ашиг шимт үржлийн мал шалгаруулах, өндөр ашиг шимтэй мал, амьтныг олон нийтэд сурталчлах, малчид, үйлдвэрлэгчдийн хөдөлмөр бүтээлийг үнэлэх, харилцан туршлага солилцох “Шилмэл мал-2019” үзэсгэлэн худалдааг Төв аймгийн Зуунмод хотноо 9 сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулав. Энэ удаагийн үзэсгэлэн худалдаанд 19 аймаг, нийслэлийн 45 сум 6 дүүргээс нийт 525 мал, амьтан, 4000 орчим хүн оролцсон нь онцлог болсон юм. Мөн орон нутгийн хэмжээнд 9 аймаг өөр өөрийн нутагтаа “Шилмэл мал-2019” үзэсгэлэнг амжилттай зохион байгуулсан.	100%
64	7.1.3. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн хооронд харилцан туршлага судлах бизнес аялал зохион байгуулдаг болно.	2019-2023			“Мал аж ахуйн үйлдвэрлэлийн механикжуулалт, цахилгаанжуулалт, малчдын хөдөлмөр ахуйн нөхцөл сайжруулах асуудал” сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал зохион байгуулав. АНУ-ын Танзас мужид болсон “Тогтвортой мал аж ахуйн хөгжилд инновацийн оруулах хувь нэмэр” сэдэвт олон улсын хуралд оролцож, туршлага солилцов. “Орчин үеийн өвс, тэжээл үйлдвэрлэлийн тогтолцоо бий болгох нь” сэдэвт БНХАУ-ын сургалтад аймаг, нийслэлийн бэлчээр тэжээл, усан хангамж хариуцсан 25 албан хаагчийг хамруулав. Канад улсад болсон “APIMONDIA 2019” дэлхийн зөгийчдийн холбооны 46-р чуулга уулзалтад оролцов. 2019 оны 6-р сард ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Саулегаар ахлуулсан МУ-ын газар тариалангийн бүсэд мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгч 16 аймгийн төлөөлөгчид Япон улсын Хоккойда мужийн Эрчимжсэн аж ахуй, мах, сүүний ашиг шимийг нэмэгдүүлэх, зохиомол хээлтүүлэг хийх дэвшилтэт аргын талаар судлав. Айлчлалын үеэр ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле Бизи, Ашоро хотын захирагч нартай уулзаж Япон Улсын эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх бодлогын талаар судлав. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНЭУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр ХХААХҮЯ-ны ТНБД-ын дарга Т.Жамбалцэрэн, тус улсын Мал аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн, загасны аж ахуйн яамны Нарийн бичгийн дарга Ш.А.Чатурвэди нар “Малын эрүүл мэнд, сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт хамтран ажиллах Иж бүрэн ажлын төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан. Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөө хөрөнгө оруулагчдын форумыг Улаанбаатар хотноо 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулав.	100%
65	7.1.4. Сүүний үхрийн, хонь,	2019-2023			2019 онд малчид, үйлдвэрлэгчдэд мэдлэг түгээх, шинэ арга технологид	100%

	ямааны эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн дунд малын нөхөн үржихүй, арчилгаа маллагаа, тэжээллэгийн мэдээлэл олгох сургалтыг тогтмолжуулна.				сургах сургалтуудыг дор дурдсан сэдвээр танхимын болон зайн хэлбэрээр зохион байгуулав. Төв аймгийн Өндөр-Ширээт суманд “Малд ангилалд хийх, сүргийн эргэлтийн талаар суурь ойлголт өгөх нь” сэдэвт сургалтад нийт 36 хүн оролцов. Төв аймгийн Борнуур суманд “Бэлчээр ашиглалтыг хариуцлага журам”-ын төслийг танилцуулж, хэлэлцүүлэгт бэлтгэх арга хэмжээнд нийт 26 хүн хамрагдав. Төв аймгийн Борнуур, Жаргалант суманд зохион байгуулсан “Тэжээлийн нэг наст ба олон наст ургамал тариалах агротехнологи” сэдэвт сургалтад нийт 180 хүн хамрагдав. Нийслэлд зохион байгуулагдсан Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх эрүүл ахуйн технологи сэдэвт сургалтад 30 хүн, Төв аймгийн Борнуур, Сүмбэр сумуудад “Бэлчээр ашиглах журмын хэлэлцүүлэг” нийт 75 хүн, Ховд аймгийн Дарви суманд “Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломж, тэжээл бэлтгэх арга” нийт 70 хүн, Ховд аймгийн Жаргалант суманд “Сүү үйлдвэрлэх технологи” сургалт нийт 100 хүн, “Сүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулалт” туршилтын төсөлд хамрагдаж буй малчид болон Төв аймгийн Борнуур, Сүмбэр сумын малчдын төлөөллийг эрчимжсэн фермерийн аж ахуйн тэргүүн туршлагатай танилцах аялалд 40 хүн, Архангай аймгийн Эрдэнэдалай суманд “Малын гаралтай түүхий эдийг стандартын дагуу бэлтгэх анхан шатны тордолт хийх технологи” сэдэвт сургалтад 160 хүн, Дархан - Уул аймагт Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээний хөгжил” сэдэвт семинар, талбайн сургалтад 35 хүн, Нийслэлд Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой ХАА төслийн хүрээнд “Экстейншиний арга зүй-Сургагч багш” сэдэвт сургалтад 25 хүн хамрагдсан. Дээрх сургалтууд бүгдэд нь сүүний үхрийн, хонь, ямааны эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн дунд малын нөхөн үржихүй, арчилгаа маллагаа, тэжээллэгийн мэдээлэл орсон болно.	
66	7.1.5. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, хүний нөөц, маркетинг, хууль зүй болон бусад чиглэлээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг системийг бүрдүүлнэ.	2019-2023			Нийслэлд эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, фермер эрхлэгчдийг чадваржуулах чиглэлээр 2019 онд 13 төрлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөөг батлуулан 6 дүүргийн ЗДТГ-тай хамтран “Залуу фермер”, “Мал аж ахуйн хоршоо”, “Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалт”, “Ферм-аялал” сургалтуудыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулж, 450 малчин, фермер эрхлэгчийг хамруулан мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Орон нутгийн экстейншиний менежерүүдэд сар тутамд экстейншиний	70%

				үйлчилгээтэй холбоотой дараах сэдвүүдээр мэдээлэл бэлтгэн и-мэйлээр хүргүүлэн, байнгын эргэх холбоотой ажиллав. Сургалт мэдээллээр дараах чиглэлийн арга хэмжээ хамаарч байна. Үүнд: ХАА-н экстейншиний тухай ойлголт, малын гаралтай түүхий эдийг стандартын дагуу бэлтгэх, хамгаалах, сайжруулах тухай “Малчин та малын эмч” малчин өрхийн малын эмийн санд анхан шатны тусламж үзүүлэхэд хэрэгтэй зүйлсийн жагсаалт, Азийн зарим улс орнуудын ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээний тогтолцоо зэрэг болно. Цаашид эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүү, хүний нөөц, маркетинг, хууль зүй болон бусад чиглэлээр мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх системийг ямар хэлбэрээр хүргэх талын судалгааны ажил хийхээр төлөвлөж байна. Эдгээр үйл ажиллагааг явуулахад төсөвөөс зардал байхгүй тул зарим ажил хэрэгжих боломжгүй болж тасарч байна.	
7.2. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн мэргэшсэн ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах,					
67	7.2.1. Эрчимжсэн мал аж ахуйд технологийн мэргэшсэн ажилтан бэлтгэх, МАА-н мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах сургалтыг тогтмол явуулна.	2019-2023		Швейцарийн хөгжил хамтын ажиллагааны агентлагаас хэрэгжүүлж буй “Ногоон алт” төсөлтэй хамтран Төв аймгийн Борнуур, Сүмбэр суманд ажиллах зохиомол хээлтүүлгийн техникчийг сургаж бэлтгэн тус бүр 4.0 сая төгрөгийн зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгслээр хангав. ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуультай хамтран: -2018-2019 оны хичээлийн жилд тусгай дунд мэргэжлийн мал зүйчид бакалаврын боловсрол олгох 1,5 жилийн сургалтад 11 мал зүйч хамрагдаж диплом гардаг авсан. 2019-2020 оны хичээлийн жилд эчнээ 2.5 жилийн сургалтад 18 мал зүйч мэргэжилтэн тус тус хамруулсан. “Бог малын ангилагч, шинжээч бэлтгэх” сургалтаар 13 аймаг, нийслэлийн 37 мал зүйчид ангилагч, шинжээч мэргэжлийн үнэмлэх олгов. МУСҮТөв, Нутаг академи ТББ-тай хамтран мал үржүүлгийн техникч бэлтгэх вакуум сургалтыг 6 аймагт зохион байгуулж, 9 мэргэжилтэнд “Мал үржүүлгийн техникч” мэргэжлийн үнэмлэх олгов. “Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэхэд дэмжлэг үзүүлэх нь” техник туслалцааны төслийн хүрээнд 21 аймаг, нийслэлийн ХХААГ-ын Мал үржлийн албаны дарга, ХААИС-ийн МААБС, МААЭШХ, Мал зүйч үржүүлэгчдийн холбоо ТББ-ын төлөөлөл бүхий 50 мал зүйчид арга зүйн сургалт зохион байгуулав. НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, мэргэшсэн шинжээч мал зүйчдийн багтай хамтран “Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх арга зүй	100%

					эзэмшүүлэх” сургалтыг 21 аймаг, нийслэлийн Мал үржлийн алба, 332 сум, 6 дүүргийн Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг технологийн хувийн нэгжийн 420 мэргэжилтнийг хамруулан зохион байгууллаа.	
7.3. Хөдөө аж ахуйн чиглэлийн шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлэх;						
68	7.3.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэхэд зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлдэг болно.	2019-2023			ХААҮШҮОНТ 2019 онд нийт 24 эрдэмтэн зөвлөхтэй гэрээ байгуулан, малчид, тариаланч, үйлдвэрлэгчдэд зориулсан ном, гарын авлага, зөвлөмж боловсруулах, сургалт зохион байгуулахад хамтран ажиллав. Мал аж ахуйн чиглэлээр 18 зөвлөх ажилласан байна. 2019 онд Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид, Бүгд найрамдах Аргентин улсын Хөдөө аж ахуйн технологийн үндэсний хүрээлэн /INTA/-ийн байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран малын тэжээлийн ургамал тариалалтын чиглэлээр хэрэгжүүлэх төслийг боловсруулж 3-н аж ахуйн нэгж дээр туршилт явуулсан нь үр дүнгээ өгсөн. Мөн ХААИС-ийн удирдлага, түүний харьяа сургуулиуд болон МААЭШХ, Ургамал хамгааллын хүрээлэн, Дарханы Газар тариалангийн хүрээлэнгийн удирдлагатай уулзалт зохион байгуулан жилийн туршид сургалт, семинар зохион байгуулах, гарын авлага, зөвлөгөө, зөвлөмж гаргах чиглэлээр хамтран ажиллав. 2020 онд энэ ажлын үр дүн нэвтрүүлэх боломжтой боллоо.	70%
7.5. Эрчимжсэн мал аж ахуйн ололт, амжилтыг урамшуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах;						
69	7.5.2. Шинэ техник, технологийн талаархи гарын авлага, мэдээлэл хүргэх.	2019-2023			“Мал аж ахуйн үйлдвэрлэлийн механикжуулалт, цахилгаанжуулалт, малчдын хөдөлмөр ахуйн нөхцөл сайжруулах асуудал” сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал зохион байгуулав. АНУ-ын Танзас мужид болсон “Тогтвортой мал аж ахуйн хөгжилд инновацийн оруулах хувь нэмэр” сэдэвт олон улсын хуралд оролцож, туршлага солилцов. “Орчин үеийн өвс, тэжээл үйлдвэрлэлийн тогтолцоо бий болгох нь” сэдэвт БНХАУ-ын сургалтад аймаг, нийслэлийн бэлчээр тэжээл, усан хангамж хариуцсан 25 албан хаагчийг хамруулав. Канад улсад болсон “APIMONDIA 2019” дэлхийн зөгийчдийн холбооны 46-р чуулга уулзалтад оролцов. 2019 оны 6-р сард ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Саулегаар ахлуулсан МУ-ын газар тариалангийн бүсэд мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй эрхлэгч 16 аймгийн төлөөлөгчид Япон улсын Хоккойда мужийн Эрчимжсэн аж ахуй, мах, сүүний ашиг шимийг нэмэгдүүлэх, зохиомол хээлтүүлэг хийх дэвшилтэт аргын талаар судлав. Айлчлалын үеэр ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле Биэи, Ашоро хотын захирагч нартай уулзаж Япон Улсын эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх	100%

					бодлогын талаар судлав. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга БНЭУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр ХХААХҮЯ-ны ТНБД-ын дарга Т.Жамбалцэрэн, тус улсын Мал аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн, загасны аж ахуйн яамны Нарийн бичгийн дарга Ш.А.Чатурвэди нар “Малын эрүүл мэнд, сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт хамтран ажиллах Иж бүрэн ажлын төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан. Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн төлөвлөгөө хөрөнгө оруулагчдын форумыг Улаанбаатар хотноо 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдөр зохион байгуулав.	
7.6. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх, үйл ажиллагааны чиглэлээр төрөлжсөн, шатлал ахисан зэрэг, дэв олгох, ажлын үр дүнгээр урамшуулах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.						
70	7.6.1. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг Малын генетик нөөцийн бүртгэлийн санд бүртгэх арга хэмжээг зохион байгуулна.	2019-2023			2019 оны хэмжээнд сүүний үхрийн гарваль ашиг шимийн бүртгэл мэдээллийн санд 32 аж ахуй нэгж иргэний 400 тоо толгой үнээ, гунжийг хамруулан бүртгэлд оруулав. 2019 онд нийт- 12500 үнээ, гунжны өглөө, оройн саамын хэмжээ, чанарын мэдээг авч, нийт 12485 дээж шинжилгээнд хамруулж мэдээллийн санд баяжуулалт хийв. Үржилд ашиглаж буй хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч малыг ялган тэмдэглэх, малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг 7 аймаг, нийслэлийн 95.7 мянган малд гүйцэтгэхээр ХХААГ-тай гэрээ байгуулж, 10.2 мянган бухыг ялган тэмдэглэж, нэгдсэн санд бүртгэлээ. Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн гоц халдварт өвчингүй, эрүүл бүсэд хамаарах Баянзүрх, Хан-Уул, Сонгино хайрхан, Налайх дүүргүүдэд байгаа 35.0 мянган үхрийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулав.	70%
71	7.6.2. Эрчимжсэн аж ахуйд ажиллаж байгаа мэргэжилтэнд шатлал ахисан зэрэг, дэв олгох арга хэмжээг зохион байгуулна.	2019-2023			Мал зүйч мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг дэв олгох асуудал нь Малын генетик нөөцийн тухай хуулийг дагалдан гарсан “Мэргэжлийн зэрэг дэв олгох, хүчингүй болгох, сунгах, бүртгэх” журмаар зохицуулагдах бөгөөд 2019 оны 3 дугаар улиралд Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны хурлын шийдвэрийг үндэслэн ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-440 дүгээр тушаалаар зөвлөх зэрэг 8 хүнд, тэргүүлэх зэрэг 8 хүнд тус тус олгосон бөгөөд үүнээс Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдээс зөвлөх зэрэг 1, тэргүүлэх зэрэг 1-ийг тус тус олгосон.	100%